



СОЁМБО



БАТЛАН ХАМГААЛАХ, ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТӨВ ХЭВЛЭЛ

2020.09.02 №34 (10711)

Үнэ 500 төгрөг

Дугаар эрхэлсэн ахлах дэслэгч М.МӨНХЗОРИГ



МЭНДЧИЛГЭЭ



Эрхэм хүндэт ахмад дайчид, үе үеийн эх орончид, Төрийн цэргийн байгууллагад алба хааж байгаа нийт бие бүрэлдэхүүн Та бүхэндээ Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойн баярын мэндчилгээг өргөн дэвшүүлье.

Өнөөдөр бид Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг дархалсан Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойг улс орон даяар, Оросын ард түмний хамт ёслол төгөлдөр тэмдэглэж байна. Монгол цэрэг Чөлөөлөх дайнд Зөвлөлт Холбоот Улсын Улаан армитай мөр зэрэгцэн Японы түрэмгийлэгчдийн эсрэг тулалдаж, гайхамшигт ялалт байгуулсан явдал Монголын XX зууны түүхэнд тодоор бичигдсэн юм. Чухамхүү энэ дайны үр дүнгээр Монгол Улс тусгаар тогтнож, бүрэн эрхт байдал улам баталгаажсан билээ.

Дэлхийн дайн Европ тивд 1945 оны 5 дугаар сард Зөвлөлт Холбоот Улс тэргүүтэй холбоотон улсуудын ялалтаар төгсөж, Ялтын бага хурлын шийдвэрийн ёсоор Зөвлөлтийн Улаан арми Японы түрэмгийлэгчдийн эсрэг дайнд орох болсон бөгөөд Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага хурал ба Засгийн газраас 1945 оны 8 дугаар сарын 10-ны өдөр "Японд дайн зарлах тухай Тунхаглах бичиг" гаргаж, Японы эсрэг дайнд нэгдсэн юм.

БНМАУ-ын Цэргийн яамны сайд, маршал Х.Чойбалсан, ЗХУ-ын хурандаа генерал Исса Александрович Плиев нарын командалсан Монгол, Зөвлөлтийн Морьт механикжуулсан бүлэг нь Өвөр Байгалийн фронтын баруун жигүүрийг халхалж, Долоннуур, Жэхэгийн чиглэлд гол цохилтыг, Хаалганы чиглэлд туслах цохилтыг хийх үүрэг хүлээжээ.

Монгол Ардын хувьсгалт цэрэг зуны аагим халуунд Цахарын өргөн цөл, урсгал догшин гол мөрнүүдийг туулан, асар богино хугацаанд 1000 гаруй километр давшиж, монгол цэргийн тэсвэр тэвчээр, монгол морины шандас хатуужлын гайхамшигийг үзүүлэн ялалт байгуулалцсан юм. Дайны өдрүүдэд манай идэр насны залуучууд цэрэгт дайчлагдан эрэлхгээр тулалдаж, үйлдвэр, хөдөө аж

ахуйн ажилчид, малчид ялалтын төлөө амсхийлгүй ажиллаж байсан нь Монголын ард түмэн нийтээрээ тусгаар тогтнолынхоо төлөө, дайны ялалтын төлөө тэмцсэний бодит түүх мөн. Чөлөөлөх дайны ялалт бол Монгол Улсын хувьд төдийгүй Ази тив, дэлхий дахины түүхэнд гүн гүнзгий ул мөрөө үлдээсэн чухал үйл явдал байсан юм.

Энэхүү түүхт ойн өдрийг тохиолдуулан өргөсөн тангарагтаа үнэнч байж, эх орныхоо газар шороо, тусгаар тогтнолын төлөө амь биеэ үл хайрлан тэмцсэн баатарлаг ахмад үеийнхэндээ гүн хүндэтгэл илэрхийлэхийн хамт тэдний гэр бүл, үр хүүхэд, төрөл төрөгсдөд чин сэтгэлийн халуун мэндчилгээ дэвшүүлье. Чөлөөлөх дайны хүндийг үүрч, ялалтын тугийг мандуулсан Зөвлөлтийн ард түмэн, түүний ялгуусан Улаан армийн баатарлаг дайчдад Монголын ард түмний нэрийн өмнөөс гүн хүндэтгэл илэрхийлж байна.

Хэдийгээр дэлхий нийтийг хамарсан цар тахлын үед Чөлөөлөх дайны түүхт ялалтын 75 жилийн ойг өндөр хэмжээнд, өргөн далайцтай тэмдэглэн өнгөрүүлэх боломжгүй байгаа ч Монгол Улсын Батлан хамгаалах яам ахмад дайчдынхаа гавьяа зүтгэлийг мөнхжүүлэн алдаршуулах олон ажлыг санаачлан хийсээр байна.

Монгол Улсын Зэвсэгт хүчин, цэрэг эрс маань өнгөрсөн зуунаас эдүгээг түүчээлэн улс орноо батлан хамгаалах нэн хариуцлагатай бөгөөд нэр хүндтэй үүргийг амжилттай гүйцэтгэж, эх дэлхийн энх тайван, амар амгаланг тогтоох үйлсэд эр зориг, тэсвэр тэвчээр, мэргэжлийн ур чадвараа гайхуулан эх орныхоо нэр хүндийг олон улсын тавцнаа дуурьсан байгааг баярын энэ өдөр тэмдэглэн хэлэхэд нэн таатай байна.

Чөлөөлөх дайнд оролцож, түүхэн ялалт байгуулсан ахмад дайчдынхаа гавьяат үйлсийг эх орны минь ирээдүй болсон хүүхэд, залуус ямагт санан суралцаж, өвлөн тээж явахыг Батлан хамгаалахын сайд би уриалж байна.

Нийт иргэд, ялангуяа залуучуудад цэрэг-эх оронч, үндэсний бахархалт үзлийг төлөвшүүлэн ёс суртахуун, сэтгэл зүйн болон бие бялдрын өв тэгш хүмүүжилтэй иргэн болгон төлөвшүүлэх нь олон улсын харилцаа ээдрээтэй болж буй энэ цаг үед төрийн алба хаагч хэн бүхний залуу хойч үеийнхээ өмнө хүлээсэн эрхэм үүрэг болж байна.

Жаран жарнаар өртөөлсөн, зуун зуунаар уухайлсан Монгол цэргийн сүлд хийморь, яруу алдар, цог жавхаа үеийн үед үүрд мандан бадрах болтугай.

Чөлөөлөх дайны ялалтын түүхт 75 жилийн ойг тохиолдуулан даян дэлхийд энх тайван тогтоох, эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг бататгах их үйлсийн төлөө халуун амь, бүлээн цусаа зориулсан эрэлхэг эх орончид, чөлөөнд болон бэлтгэлд байгаа ахмад дайчид, тэдний гэр бүлийнхэн, Монгол цэргийн түүхийг бахархам үйлсээрээ баяжуулж буй Та бүхэндээ чин сэтгэлийн баярын мэндчилгээ дэвшүүлье.

Эх орныхоо тусгаар тогтнолыг дэлхий дахинд хүлээн зөвшөөрүүлэхэд жинтэй хувь нэмэр оруулсан XX зууны түүхэн үйл явдал болох 1939 оны Халхын голын байлдаан, 1945 оны Чөлөөлөх дайнд Монгол-Зөвлөлтийн дайчид мөр зэрэгцэн тулалдаж, мөнхөд дуурьсагдах ялалтыг байгуулсан билээ.

Чөлөөлөх дайны ялалт нь хүн төрөлхтний түүхэн дэх хөнөөлт дайны сүүлчийн голомтыг устгах, Зүүн өмнөд Азид амар амгалан байдал бий болгох, Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлыг олон улсад бататгах нөхцөлийг бүрдүүлсэн чухал ач холбогдолтой юм.

Монгол-Зөвлөлтийн дайчид нэгэн зорилгын төлөө байгаль, цаг агаарын хүнд нөхцөлд их элсэн цөл, өндөр уул даваа, өргөн гол мөрнийг гатлан, Чуулалт хаалга, Долоннуур, Жэхэгийн чиглэлд мянга гаруй километр давшин тулалдсан нь цэрэг эрсийн тэвчээр хатуужил, монгол хүлгийн шандсыг шалгасан түүхэн сорилт байсан.

Чөлөөлөх дайны ялалтын ой нь Монгол-Зөвлөлтийн ард түмний найрамдалт харилцаа, итгэл найдвар, дайчин нөхөрлөл, хамтын тэмцлийн үл мартагдах түүхийг эргэн дурсах тэмдэглэлт үйл явдал бөгөөд эх орноо хайрлах, эр цэргээрээ бахархах, газар шороо, эрх чөлөөнийхөө үнэ цэнийг мэдрэх, эх оронч үзлийг түгээн дэлгэрүүлэх боломжийг бид бүхэнд олгож байна.

Эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолын төлөө тэмцсэн цэрэг эрсийн баатарлаг гавьяа, ахмад үеийнхээ эх оронч үйл хэргийг алдаршуулан мөнхжүүлж, хойч үедээ өвлүүлэн үлдээх нь бид бүхний үүрэг, хариуцлага билээ.


Чөлөөлөх дайнд оролцож, дэлхий дахинд амар амгаланг тогтоох ариун үйлсэд залуу халуун нас, амь биеэ зориулан баатарлаг гавьяа байгуулсан эх орончид, ахмад дайчид болон тэдний гэр бүл, Төрийн цэргийн байгууллагын нийт бие бүрэлдэхүүн Та бүхэнд Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойн баярын мэндийг дахин хүргэж, эрүүл энх, аз жаргал, хамгийн сайн сайхан бүхнийг хүсэн өрөөе.

Монгол цэргийн сүр хүч, цог золбоо мандан бадрах болтугай.

МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА, ХОШУУЧ ГЕНЕРАЛ Д.ГАНЗОРИГ



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮН, БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД Г.САЙХАНБАЯР



ОНЦ БӨГӨӨД БҮРЭН ЭРХТ ЭЛЧИН САЙД ИЙРЖИ БРОДСКИЙГ ХҮЛЭЭН АВЧ УУЛЗАВ

Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Бүгд Найрамдах Чех Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Ийржи Бродскийг хүлээн авч уулзав.

Уулзалтын үеэр талууд хоёр орны харилцаа, батлан хамгаалах салбарын өнөөгийн байдал, цаашид авах арга хэмжээний талаар санал солилцлоо. Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр Монгол Улс, Бүгд Найрамдах Чех Улсын харилцаа олон

жилийн түүхтэй, ялангуяа аж үйлдвэрлэлийн салбарын харилцаа өнөөг хүртэл өргөжин хөгжсөөр ирснийг тэмдэглээд цаашид нийгмийн бүхий л салбарт хамтын ажиллагаа өргөжин тэлнэ гэдэгт итгэлтэй байна гэдгийг онцолсон юм.

Элчин сайд Ийржи Бродский сайд Г.Сайханбаярт Батлан хамгаалахын сайдаар томилогдсонд нь баяр хүргэж, амжилт хүсээд БНЧУ-ын Батлан хамгаалахын сайд Любомир Мэтнараас ирүүлсэн баярын захидлыг гардуулан өгсөн юм.

М.ЭСПЕР САЙД Г.САЙХАНБАЯРТ БАЯР ХҮРГЭЖ, АМЖИЛТ ХҮСЭВ



Монгол Улсын Засгийн газрын гишүүн, Батлан хамгаалахын сайд Г.Сайханбаяр АНУ-ын Батлан хамгаалахын сайд М.Эспертэй өөрийнх нь хүсэлтээр утсаар ярих. М.Эспер, сайд Г.Сайханбаярыг шинээр эмхлэн байгуулагдсан Монгол Улсын Засгийн газарт Батлан хамгаалахын сайдаар томилогдсон баяр хүргээд, ажлын амжилт хүсэв. Түүнчлэн сайд нар хоёр орны батлан хамгаалах салбарын хамтын ажиллагааны талаар санал бодлоо солилцлоо.

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ЖАНЖИН ШТАБЫН ДАРГА НАР ЦАХИМААР ХУРАЛДЛАА



Энэтхэг-Номхон далай дахь АНУ-ын цэргийн командлагч, адмирал Ф.Давидсон тэргүүлж тус бүс нутгийн 27 улсын Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга нар оролцсон цахим хурал амжилттай зохион байгуулагдлаа. 22 дахь жилдээ зохион байгуулагдсан тус хурал анх удаа цахимаар явагдсанаараа онцлог байсан юм.

Дээрх хуралд АНУ-ын Батлан хамгаалахын сайд М.Эспер, Нэгдсэн штабын дарга, генерал М.Миллей нар оролцож

эдийн засгийн салбарт тулгарч буй хүндрэл бэрхшээлийн талаар танилцуулж, санал бодлоо солилцов. Хурлын үеэр холбоо, мэдээллийн тавдугаар үеийн техник, технологи нь цэргийн хэрэгт хэрхэн нэвтэрч буй болон үндэсний аюулгүй байдлыг хангах боломжит нэгэн арга хэрэгсэл байж болох талаар танилцуулсан нь хуралд оролцогчдын сонирхлыг ихээр татаж байв.

Дараагийн хурал энэ онд Фижи улсад болохоор



"Чөлөөтэй, нээлттэй Энэтхэг-Номхон далайн бүс нутаг дахь хамтын ажиллагааг сайжруулах нь" сэдвийн хүрээнд хуралд оролцогч улс орнуудын Жанжин штабын дарга нартай харилцан санал солилцов. Мөн хуралд оролцогч орнуудын Жанжин штабын дарга нар дэлхий нийтэд тархсан цар тахлын улмаас тухайн улсын үндэсний аюулгүй байдалд хэрхэн нөлөө үзүүлж, улс төр, батлан хамгаалах болон

төлөвлөгдсөн хэдий ч цар тахлын улмаас тус улсад 2021 онд зохион байгуулахаар дахин товлов.

Ирэх онд зохион байгуулах тус хурлаар коронавирусийг хэрхэн даван туулсан, Энэтхэг-Номхон далай дахь бүс нутгийн аюулгүй байдалд ямар нөлөө үзүүлсэн талаар мөн цаашдын хамтын ажиллагааг хөгжүүлэхэд анхаарах зэрэг асуудлаар харилцан туршлага, санал солилцохоор төлөвлөв.

ШИНЭ АХЛАГЧ НАР НОМЫН ДУУ СОНСЛОО



Зэвсэгт хүчний Жанжин штабын ахлагч, тэргүүн ахлагч Б.Гантөмөр Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийг төгсөж буй сонсогчидтой уулзалт зохион байгууллаа. Энэ үеэр Зэвсэгт хүчний эгнээнд, ахлагчийн албанд томилогдон ажиллаж эхлэхтэй нь холбогдуулан Зэвсэгт хүчний ахлагчийн албаны түүх, эрх зүйн орчин, сургалт болон ахлагчийн бүрэлдэхүүний албандаа хандах хандлага, ёс зүйн талаар яриа танилцуулга хийсэн юм. Тэрээр уулзалтын төгсгөлд шинэхэн ахлагч нарт "Хүн бүр хариуцсан албандаа үлгэр жишээч, сурч мэдэхийн их хүсэл тэмүүлэлтэй байгаарай. Бүтээлч, санаачилгатай бай. Дарга нарынхаа итгэлийг зүтгэлээр хариулаарай" гэж захиад цаашдын албанд нь өндөр амжилтыг хүссэн юм.

СОНСОГЧИД ЦЭРГИЙН ТАНГАРАГ ӨРГӨЛӨӨ



Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн Цэргийн нэгдсэн дээд сургууль болон Батлан хамгаалах мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвд 2020-2021 оны хичээлийн жилд элсэн суралцагчдын Цэргийн тангараг өргөх ёслолын ажиллагаа тус сургуулийн "Шархад" хээрийн сургалтын төвд боллоо. Цэргийн тангараг өргөх ёслолд Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Д.Баасандамба, Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн захирал, бригадын генерал П.Жаргалан болон тангараг өргөж буй бүрэлдэхүүн оролцсон юм. Сонсогчид цэргийн тангараг өргөсний дараа Байлдааны туганд мэхийн ёсолж хүндэтгэл үзүүлээ.

Батлан хамгаалах яамны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа Д.Баасандамба Цэргийн тангараг өргөсөн сонсогчдод баяр хүргээд "Батлан хамгаалах салбарын 100 гаруй жилийн түүхэн хугацаанд Батлан хамгаалахын их сургуулийг төгссөн төр, нийгэм, цэргийн олон арван зүтгэлтнүүд, генерал, офицер, багш, эрдэмтэн, судлаач Монгол эх орныхоо тусгаар тогтнол, улс орны аюулгүй байдлыг хангах, батлан хамгаалах бодлого, тогтолцоо, эрх зүйн шинэчлэл, Зэвсэгт хүчний байгуулалтыг боловсронгуй болгон хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулсаар ирсэн. Үүний зэргээс даян дэлхийн энх тайван, амар амгалангийн төлөө дэлхийн халуун цэгүүдэд олон улсын цэргийн болон НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд үүргээ нэр төртэй гүйцэтгэж байгаа олон улсын хамтын нийгэмлэг, Монголын төр, ард түмэн сайн мэднэ. Үндэсний батлан хамгаалахын их сургуульд элсэн орж, цэргийн тангаргаа өргөж байгаа тул та бүхэн эрдэм, мэдлэгт шамдан суралцаж, Монгол Улсынхаа хөгжил цэцэглэлт, Батлан хамгаалах салбартаа ихийг хийж бүтээнэ гэдэгт бид итгэж байна" гэв.


Дэлхий нийтэд тархаад буй коронавирусийн цар тахлаас үүдэн сонсогчдын цэргийн анхан шатны бэлтгэлд өөрчлөлт орсон эсэх талаар ҮБХИС-ийн Сонсогчийн батальоны захирагч, дэд хурандаа Ж.Урантөгсөөс тодруулахад, "ҮБХИС-ийн 2020-2021 оны хичээлийн жилийн төлөвлөгөөний дагуу цэргийн анхан шатны бэлтгэл сургалт амжилттай явагдаж өндөрлөв. Сонсогчид эх орондоо үнэнчдийн баталгаа болсон цэргийн тангаргаа өргөлөө. Сургалт хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу цэргийн дүрэм, жагсаалын бэлтгэл, биеийн тамир, галын бэлтгэл гэсэн дөрвөн төрлөөр явагдсан. Коронавирусийн цар тахлын улмаас шалтгаалан зарим хичээлд бага зэрэг өөрчлөлт орсон. Тухайлбал, жагсаалын бэлтгэл хичээлийг зохион байгуулахдаа цэргийн алба хаагч хоорондын болон эгнээ хоорондын зайг нэг

метр болгосон. Сургалтыг анх удаа ийм шинэлэг байдлаар явууллаа" гэсэн юм.

Эрчүүдтэй мөр зэрэгцэн алба хааж буй энэ сонсогчийг Б.Цэнд-Аюуш гэдэг. Түүний хувьд 2018 оноос ҮБХИС-ийн Аюулгүй байдлын сургуульд суралцаж эхэлсэн бөгөөд цэргийн анхан шатны сургалтад хамрагдан цэргийн тангаргаа өргөснөөр Цэргийн нэгдсэн дээд сургуульд суралцах боломж нь нээгдсэн байна. Тэрээр хэлэхдээ "Миний гэр бүл, ойр тойрныхонд цэргийн хүн цөөнгүй бий. Өсөж төрсөн орчин, өөрийн хүсэл сонирхолдоо хөтлөгдөн ҮБХИС-д элссэн. Өнгөрсөн хугацаанд цэргийн хүн ямар байх ёстой талаар зах зухаас нь мэдэрдээ. Цэргийн анхан шатны сургалтын явцад бүх зүйлийг бататгасан гэж бодож байна. Энэхүү сургалтаар өөрийнхөө сул талыг засах, сайн талаа улам хөгжүүлэхийг зорьсон. Сургалтын ач тусыг хүртэж, зорилгоо бага ч атугай биелүүлсэндээ баяртай байна. Тангараг өргөх мөч хамгийн сайхан байсан шүү" гээд баярын сэтгэгдлээсээ хуваалцсан.



Дараагийн онцлох сонсогч нь Х.Дамдиндорж.



Салаа, ротынхон нь түүнийг дуулдаг, сайхан хоолойтой гэдгээр нь андахгүй. "Дуучин Дамдин" ч гэж цоллох нь холгүй аж. Тэрээр цэргийн тангараг өргөсөн сэтгэгдлээ хуваалцаж "Монгол Улсын Төрийн дууллыг эгшиглэхэд омогших мэдрэмж төрлөө. Цэргийн анхан шатны сургалтад хамрагдан цэргийн тангараг өргөснөөр эх орныхоо үнэ цэнийг илүүтэй мэдэрдээ. Аав маань цэргийн хүн болохоор намайг их журамтай хүмүүжүүлсэн. Ер нь цэргийн мэргэжлийн хүн бусад салбарынхаас үүрэг, даалгаврыг цаг тухайд нь биелүүлдэг, тууштай, шийдэмгий, зохион байгуулалт сайтай, хариуцлага даадаг зэрэг олон чанараараа ялгарах байх гэж боддог" гэлээ.

Редакцын шууданд

011 дүгээр анги

Анги, салбарын санхүүгийн дарга, ахлах нягтлан бодогчийн ажлын үр дүнг үнэлэх, шагнал урамшуулал олгох журам"-ын үнэлгээ, 2019 оны жилийн эцсийн тайлан балансын нэгдсэн дүнгээр Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн Санхүүгийн тасгийн дарга, хошууч Э.Мэнджаргал тэргүүлж, Зэвсэгт хүчний Жанжин штабын даргын тушаалаар иж бүрэн компьютероор шагнууллаа.

Хошууч Ж.ТӨГСМАНДАХ

013 дугаар анги

Бие бялдрыг хөгжүүлэх, чийрэгжүүлэх зорилгоор албан тушаалтнуудын дунд "Эрүүл мэнд-дугуйн аялал" хөтөлбөрийг зохион байгууллаа.



Хөтөлбөрийн эхэнд тус ангийн штабын дарга, хурандаа О.Заяат бие бүрэлдэхүүнд хандаж хэлсэн үгэндээ "2019-2020 оны сургуулийн жилд өөрийгөө хөгжүүлэх, бие бялдрын зохистой харьцааг хангах, цар тахлын үед биеийн дархлааг сайжруулах үүднээс дугуйн спортоор хичээллэж байгаад

талархал илэрхийлье. Цаашид энэхүү хөтөлбөр өргөжиж илүү олон хүн хамрагдана гэдэгт итгэж байна" гээд зарим албан тушаалтанд талархал гардуулан амжилт хүсэв. Түүнчлэн бие бүрэлдэхүүний дугуйны хэрэглээг дэмжих үүднээс дугуйны зогсоол байгуулснаа энэ үеэр дуулгав. Дугуйн аялалд оролцох бүрэлдэхүүн ангийн байрлалаас 45 километр зайд хөдөлгөөн үйлдэж товлосон цэртээ хүрсний дараа гурван төрлийн хөгжөөнт тэмцээнийг зохион байгуулсан юм.

Уулын оргил булаалдах тэмцээний дүнгээр эрэгтэйчүүдээс тэргүүн байрт дэд ахлагч Х.Эрхэмбаяр, дэд байрт ахмад Д.Болдбаатар шалгарлаа. Энэ төрөлд эмэгтэйчүүдээс дэслэгч Б.Нангид тэргүүлж, ахлагч Н.Ууганцэцэг удаалж өргөмжлөл, үнэ бүхий зүйлээр шагнагдлаа.

Мөн Дартс шидэлтийн аварга шалгаруулах тэмцээнд ахмад Д.Болдбаатар, ахлагч Ц.Анхцэцэг нар шалгарсан юм. Хөгжөөнт тэмцээний тэргүүн байранд түрүүч С.Гантулга, дэд байранд дэслэгч М.Ариунтуяа нар шалгарав. Ахмад Ц.ЦЭВЭГДОРЖ

350 дугаар анги

"2019-2020 оны сургуулийн жилийн сургалт бэлтгэлийн төлөвлөгөөний дагуу "Ангийн захирагчийн нэрэмжит төгсгөлийн шалгалт"-д бие бүрэлдэхүүн амжилттай хамрагдлаа.

"Зэвсэгт хүчний Жанжин штабын сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу "Тусгай хүчний сургалт"-ыг Таван толгойн районд зохион байгууллаа. Энэхүү сургалтаар "Амьд гарах ухаан", "Ойрын зайн хурдан буудлага", "Холбооны бэлтгэл", "Хоногийн 10, 20, 30 километрийн марш", "Уулын сургалт" -ыг зохион байгуулж явууллаа.

М.БОЛОРТУЯА

ДУГААРЫН СУРВАЛЖИЛГА

ТЕХНИК, ТАБЕЛЬ ХЭРЭГСЛИЙН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭХ БЭЛЭН БАЙДАЛ ДЭЭШЛЭВ

ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон Засвар үйлчилгээ, сургалтын бүлгүүд Зэвсэгт хүчний 256 дугаар ангид удаан хугацааны хадгалалтад

хувьсгалтай нас чацуу. Тиймээс ирэх жил байгуулагдсаныхаа 100 жилийн ойг ёслол төгөлдөр тэмдэглэхээр төлөвлөж байгаа аж. Иймд дээрх засвар,

Түүнээс хойш тус ангийн удаан хугацааны хадгалалтад байгаа техник, хэрэгслүүдэд нэгдсэн байдлаар өнөөдрийнх шиг өргөн хэмжээгээр засвар үйлчилгээ хийгдээгүй байсан. Тэгвэл ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон Засвар үйлчилгээ, сургалтын бүлгүүд болон тус ангийн цэргийн алба хаагчид шахуу төлөвлөгөөгөөр 20 гаруй хоног ажиллан энэхүү ажлын ард гарлаа. Тэд тус хорооны үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэхэд ихээхэн хувь нэмрээ орууллаа" гэсэн юм.

Тус ангид хуягт танкийн засвар, үйлчилгээний болон ар талын тусгай тоноглолтой

"Зэвсэгт хүчний хэмжээнд 2018 онд явагдсан цэргийн зэвсэглэл, техник, ар талын табель, хэмжих хэрэгслийн нэгдсэн тооллогын үр дүнгээр анги, нэгтгэлүүдэд удаан хугацааны хадгалалтад байгаа техник, зэвсэглэл, ялангуяа ар талын тусгай тоноглолтой техник, табель хэрэгсэлд засвар үйлчилгээ хийж, үүрэг гүйцэтгэх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээг хэрэгжүүлэх нь зүйтэй гэж үзсэний үндсэн дээр энэхүү ажлыг зохион байгууллаа. Мөн анги, салбаруудад ар талын техник, табель хэрэгсэлд засвар үйлчилгээ хийх чадвартай мэргэжлийн бүрэлдэхүүн ховор байгаад үндэслэн тодорхой

нь нэмэгдсэн гэдгийг онцлон тэмдэглэе. Анги, салбарууд өдөр тутам ашиглагдаж байгаа техник, табель хэрэгслүүддээ урсгал засварыг хийдэг ч удаан хугацаанд хадгалагдаж байгаа ар талын тусгай тоноглолтой техник, табель хэрэгслүүддээ засвар үйлчилгээ хийж чаддаггүй. Төсөв, хөрөнгийн байдлаас хамаарч тийм боломж ч хомс байдаг. Тиймээс бид Зэвсэгт хүчний ангиудад хийгдэж байгаагүй томоохон ажлыг эхлүүлээ. Цаашдаа бусад анги, салбарт ч энэ чиглэлийн ажлыг хэрэгжүүлж, удаан хугацаанд хадгалагдаж байгаа техник, табель хэрэгслүүдийн



байгаа ар талын тусгай тоноглолтой техник, табель хэрэгсэл болон хуягт танкийн техникт засвар, үйлчилгээг хийлээ. Мөн Зэвсэгт хүчний 016, 167, 186, 256, 310, 336 дугаар ангийн ар талын табель хэрэгслийн засварчидтай сургалт явуулж, тэдний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлсэн юм.

Энэхүү засвар, үйлчилгээний ажлын чанар байдалтай танилцаж, тооллого хийхээр ЗХЖШ-ын Ар талын газрын Материал хангалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Б.Батнямаар ахлуулсан бүрэлдэхүүн 8 дугаар сарын 28, 29-ний өдөр тус ангид ажилласан юм.

Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн түүх нь Ардын

үйлчилгээний ажил нь тэрхүү их ойн өмнө хийгдэж буй томоохон ажлуудын нэг гэдэг нь тодорхой. Энэ тухай тус ангийн захирагч, хурандаа Б.Галбадрах хэлэхдээ "Танкийн тусгай хороо нь ирэх жил байгуулагдсаныхаа түүхт ойг тэмдэглэхээр шаргуу ажиллаж байна. Мэдээж энэхүү ойгоо их бүтээн байгуулалт, ололт, амжилтаар угтахаар хүн бүр дор бүрнээ сэтгэл гарган ажиллаж байгааг дурдах нь зүйтэй. Тус анги нь 1987 онд одоогийн байршилдаа шилжиж ирсэн. Бүхэл бүтэн дивиз нүүж ирж байсан учир их хөл хөдөлгөөний үед, мөн шилжилтийн нийгмийн ороо бусгаа үед ангийн зарим техникийн эд ангиуд нь тодорхой хэмжээгээр тоногдож, алга болж байсан юм билээ.



техник, табель хэрэгслийн засвар үйлчилгээний гэсэн хоёр үндсэн бүлэг ажилласан. Энэ тухай Зэвсэгт хүчний Жанжин штабын Ар талын газрын Материал хангалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, хурандаа Б.Батням

албан тушаалтнуудыг энэ ажилд сургаж мэргэшүүлэх хэрэгцээ шаардлага үүссэн юм. Үүгээр дан ганц тус ангийн бэлэн байдал дээшлээд зогсохгүй бусад ангийн зарим албан тушаалтнуудын мэргэжлийн ур чадвар, дадлага

үүрэг гүйцэтгэх бэлэн байдлыг дээшлүүлэх чиглэлд анхаарч ажиллана" гэв. Ингээд энэхүү бүтээлч ажилд гар бие оролцсон цэргийн алба хаагчдын сэтгэгдлээс хүргэе.

ОРОС ТЕХНИКИЙН ЧАНАР, БАТ БӨХ БАЙДЛЫГ МАГТАХ УЧИРТАЙ



Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Хуягт техникийн инженер, ахмад Т.БАТСАЙХАН:

-Би 2010 онд Батлан хамгаалахын их сургуулийг хуягт танкийн офицер мэргэжлээр төгссөн. Зэвсэгт хүчний 167 дугаар ангид 2015 он хүртэл ажиллаад тус ангид томилогдсон.

Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн мэргэжилтнүүд, тус ангийн хуягт техникийн засварын бүлгийн 28 алба хаагчидтай хамтран танк, явган цэргийн байлдааны машин болон танкийн чирэгчид засвар, үйлчилгээг хийлээ. Мэргэжлийн хүмүүстэй хамтран нэгэн баг болж ажилласан болохоор бид их зүйлийг сурлаа. Удаан хугацаанд хадгалагдаж байгаа техникүүд нь тус анги нүүж ирсэн буюу 1987 оноос хойш засварт ороогүй байсан учир бүх резинэн эдлэлүүд болоод зарим эд, ангиуд нь муудаж, тос, масло нь холилдон байсныг бид засаж, үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгосон. Тайван цагийн орон тоонд ашиглагдаж байгаа техникүүддээ бид жил бүр урсгал засвар хийдэг ч энэ удаагийнх шиг бүх техниктээ засвар хийж байгаагүй. Мөн онцлоход, 30 гаруй жил хөдлөөгүй байсан дөрвөн нэгж танкийн чирэгчид засвар хийж, үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгосон. Анх засварчид маань бараг л асахгүй байх гэж бодож байсан ч эд, ангиудыг нь сэргээн засварлаад асаахад байдал шал өөр байсан. Аргагүй л орос техникийн яс чанар, бат бөх байдлыг магтах учиртай.

ТЭД ОДОО МЭРГЭЖЛИЙН БОЛСОН



Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн тоног төхөөрөмжийн засварчин, ахлагч ТҮВШИНХИШИГТ:

-Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн тоног төхөөрөмжийн засварчин тасгаас гурван хүний бүрэлдэхүүн тус ангид ирж ажиллалаа. Бид "КП-125" чиргүүлийн тогоо, "ПП-40", "КО-75", "МК-30" зөөврийн тогоо, хээрийн механиксан талхан завод зэрэг ар талын техник, табель хэрэгслүүдэд засвар хийсний зэрэгцээ Зэвсэгт хүчний зургаан ангиас ирсэн тодорхой

тооны хүмүүст сурган зааварлах хичээлийг явууллаа. Суралцагчдын идэвх оролцоо сайн байлаа. Бид суралцагчдаа техник, хэрэгслийг арчиж, зүлгэхээс нь эхлээд заасан. Дараа нь тоног төхөөрөмжүүдийн үүрэг, зориулалт, ашиглалт, хамгаалалтыг нь заасан. Тэд эхэндээ ар талын табель хэрэгслүүдийг даралтын зарчмаар ажиллагдгийг ч мэдэхгүй байсан бол одоо мэргэжлийн түвшинд эзэмшдэг болсон.

Мэдээж, удаан хугацаанд хадгалагдаж байсан учир зөөврийн тогоонуудын түлшний насос нь бөглөрсөн, дугуйнууд нь язарч муудсан, эд ангиуд нь зэвэрсэн зэрэг олон төрлийн гэмтэлтэй байсныг бид засварлаж чадсандаа баяртай байна.

АНГИДАА ОЧООД МЭДСЭН СУРСНАА ЗААЖ ӨГНӨ



Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн автын засварчин, дэд ахлагч М.АМАРМӨРӨН:

-Би 2018 онд ҮБХИС-ийн Ахлагчийн сургуулийг төгсөөд Өмнөговь аймагт томилогдсон. Манай гэр бүлд цэргийн мэргэжлийн хүн байдаггүй. Дунд

сургуульд байхдаа Налайх дүүргээс цэрэг-спортын "Дөл" тэмцээнд удаа дараа оролцож, тэргүүлж байсан. Тиймээс сурагч байхаасаа л цэргийн дүрэмт хувцас өмсөөд жагсаалд нэгдэж, эх орондоо тангараг өргөхийг хүсдэг байлаа. Хүслээ ч биелүүлэн өөрийн хүсэл сонирхлоороо цэргийн албанд орсон. Ойрын зорилго маань үргэлжлүүлэн суралцаж, офицерын албанд дэвшин ажиллах явдал.

Тус ангид ирээд ах нараасаа их зүйлийг сурч байна. Миний хувьд ар талын табель хэрэгслийн талаарх мэдэгдэхүүн төдийлөн байгаагүй. Харин энэхүү сургалтад хамрагдсанаар иж бүрэн мэдлэгтэй боллоо. Зэвсэгт хүчинд олон жил ажилласан туршлагатай алба хаагчид техник, тоног төхөөрөмж дээр ажиллах арга зүй, дадлагын хичээлийг чин сэтгэлээсээ зааж зөвлөж байгаа нь дотно санагдсан. Цаашид ангидаа очоод ар талын мэргэжилтэй ахлагч нартаа мэдсэн сурснаа зааж өгнө гэж бодож байгаа.

БАЙНГЫН БҮРЭЛДЭХҮҮНИЙ ЭГНЭЭНД ШИЛЖИЖ, АЛБА ХААЖ ЯВААДАА БАЯРТАЙ БАЙНА

Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн Батальоны ахлах тогооч, дэд ахлагч Ж.ЯЛАЛТБАЯР

-Би 2012-2013 онд Зэвсэгт хүчний 186 дугаар ангид хугацаат цэргийн алба, 2013-2017 онд цэргийн гэрээт албыг хаасан. 2015 онд БНӨСУ-д НҮБ-ын мандаттай энхийг сахиулах ажиллагаанд Монгол Улсын Зэвсэгт хүчний 5 дугаар ээлжийн Цэргийн багийн бүрэлдэхүүнд багтаж, энхийг сахиулсандаа баярлаж явдаг. Дараа нь ахлагчийн албанд шилжээд 2019 онд Афганистан улсад явагдаж байгаа "Тогтвортой эрх чөлөө" ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн. Хугацаат цэргээс Зэвсэгт хүчний байнгын бүрэлдэхүүний эгнээнд шилжиж, алба хааж яваадаа баяртай байна.

Анх ирээд шатахуун тээвэрлэдэг "Урал АЦ-5" загварын машинд түлшийг хэрхэн соруулж, түгээх аргад суралцсан. Дараа нь зөөврийн тогоонуудыг шингэн түлшээр хэрхэн



ажиллуулах, аюулгүйн ажиллагааны арга барил зэрэгт суралцсан. Багш нарын мэдлэг, чадвар өндөр байлаа. Тогооч бидний мэргэжлийн ур чадварыг нэмэгдүүлсэн дээрх ажил шиг олон төрлийн ажил, арга хэмжээг Зэвсэгт хүчинд явуулж байгаасай гэж боддог.

ХИЙСЭН АЖЛАА ТООЧВОЛ ИХ



Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн Материал техникийн хангалтын салааны жолооч, дэд ахлагч Д.РЭНЦЭНДОРЖ:

-Би авто машины талаар мэдэхээс бус ар талын

табель хэрэгслүүдийн талаар ямар ч ойлголтгүйгээр тус сургалтад хамрагдсан. Үнэхээр бодож байснаас ч их зүйлийг сурлаа, сурах ч зүйл ихтэй мэргэжил юм. "ПП-40", "КП-125" зэрэг зөөврийн тогоог ажиллуулахад амаргүй санагдлаа. Шингэн түлшээр ажилладаг учир аюулгүйн ажиллагааг нь сайтар мөрдөж, тус төхөөрөмжийн талаар бүх талын мэдлэгтэй байхгүй бол өөрийгөө ч, өрөөлийг ч эрсдэлд оруулах магадлалтай гэдгийг мэдэж авлаа. Удаан хугацааны хадгалалтад байсан ар талын хэрэгслүүдэд өмнө нь ингэж олноор нь засвар, үйлчилгээ хийж байгаагүй. Тухайлбал, зөөврийн тогоонуудыг агуулахаас гаргалаа гэж бодоход дугуйнууд нь элэгдэж, муудсан, зарим эд ангиуд нь ашиглалтаас гарсан байх нь элбэг. Хэдий тийм ч манай бүлэг тэдгээрийн эд ангиудыг нь сэлбэж засварлаад үүрэг гүйцэтгэхэд бэлэн болгосон. Цоорсон эд ангиудыг нь гагнаж, түлшний насосыг нарийн сэтгүүрээр сэтгэж, янзалсан гээд хийсэн ажлаа тооцоод байвал их бий.



ЯЛАЛТЫН ТҮҮХЭН АЧ ХОЛБОГДОЛ

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Зэвсэгт хүчний Ерөнхий дээд командлагч 1945 оны 8 дугаар сарын 23-ны өдөр тушаал гаргаж, Алс Дорнодын давших байлдаан ялалтаар дууссаныг Зөвлөлтийн арми, ард түмэнд мэдэгджээ. Тушаалд Алс Дорнодын байлдаанд Монгол ардын хувьсгалт цэргийн дайчид гарамгай байлдсаныг тэмдэглээд 8 дугаар сарын 23-ны өдрийн 22.00 цагт Москва хотноо 324 их буугаар 24 удаа ёслолын буудлага хийж, Өвөр Байгал, Алс Дорнодын фронтын цэрэг, Номхон далайн флот мөн маршал Чойбалсангийн армид баяр хүргэн ёслол үйлдсүгэй гэжээ. Ийнхүү Алс Дорнодод явуулсан дайн ялалтаар дуусаж, 1945 оны 9 дүгээр сарын 2-ны өдөр Америкийн "Миссури" хөлөг онгоц дээр Япон улс бууж өгөх тухай актад гарын үсэг зурснаар дэлхийн хоёрдугаар дайн төгсгөл болов.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсад 9 дүгээр сарын 3-ны өдөр ялалтын баярыг өргөн дэлгэр тэмдэглэн Сүхбаатарын өргөн чөлөөнд баярын цуглаан болж, Монгол ардын хувьсгалт цэргийн Улс төрийн газрын дарга Ю.Цэдэнбал баяр хүргэн үг хэлэв. Баярын цуглаанд оролцогчид ЗХУ-ын удирдагч И.В.Сталин, В.М.Молотов, Өвөр Байгалийн фронт командлагч, маршал Р.Я.Малиновский нарт баярын цахилгаан илгээжээ. Ялалтын баярт зориулан Улсын хөгжимт драмын театр, Улсын циркийн жүжигчдийн тоглолт болж мөн өдрийн орой 21.00 цагт Сүхбаатарын өргөн чөлөөнд ёслолын буудлага, олон нийтийн цэнгүүн болжээ. Мөн хөдөө, орон нутагт ялалтын баярыг өргөн дэлгэр тэмдэглэв. Чөлөөлөх дайнд оролцсон Монгол ардын хувьсгалт цэргийн анги, нэгтгэлүүдэд болон чөлөөлөгдсөн хотуудад ялалтын баярыг тэмдэглэж, Монгол, Зөвлөлтийн армийн баатарлаг дарга, цэргүүдэд баяр хүргэжээ. Энэ үед маршал Х.Чойбалсан Өвөр Монголд очиж, анги, нэгтгэлд болсон баярын цуглаанд оролцон, Байлдааны шинэ туг гардуулан Монгол, Зөвлөлтийн дайчдад баяр хүргэжээ. Түүнийг ЗСБНХУ-аас БНМАУ-д суугаа Элчин сайд И.А.Иванов, Монгол ардын хувьсгалт цэргийн зөвлөх бөгөөд Жанжин штабын дарга, дэслэгч генерал И.Г.Рубин нар дагалдан явсан бөгөөд тэд цэргийн анги, нэгтгэлээр явж баяр хүргэснээс гадна чөлөөлөгдсөн хот, тосгодын түүх, дурсгалт газруудыг үзэн Цагаан хэрэм дээр гарсан байна.

Маршал Х.Чойбалсан, Элчин сайд, хошууч генерал И.А.Иванов, хурандаа генерал И.А.Плиев, дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн нар Луаньин хотноо байрлаж байсан 8 дугаар морьт дивиз дээр 9 дүгээр сарын 3-ны өдрийн 15.00 цагт хүрэлцэн очжээ. Тэднийг цэргийн хуарангийн дундах өргөн чөлөөнд гоёмсоор чимэглэсэн индрийн дэргэд хүрэлцэн очиход дивизийн дарга, дэд хурандаа Одсүрэн илтгэл өгч хөгжим эгшиглэн маршал Х.Чойбалсан дарга, цэргүүдтэй мэндчилэн ялалтын баяр хүргэжээ. Маршалыг баяр хүргэсний дараа дахин хөгжим эгшиглэж, дарга, цэргүүдийн

сүрлэг уриа цуурайтан байх үед маршал Х.Чойбалсан индэр дээр гарч үг хэлэв. Түүний дараа анги, салбарууд индрийн өмнүүр баярын жагсаалаар явж тус тусын байрлалдаа очихдоо "Манай наран маршал Чойбалсан" хэмээх дууг дуулан явж байсан тухай түүхэн баримтад тэмдэглэжээ.

Ийнхүү 1945 оны 9 дүгээр сарын 3-ны өдөр Монголын ард түмэн, армийн дайчид ялалтын баярыг Улаанбаатар хот, хөдөө, орон нутагт төдийгүй чөлөөлөгдсөн хотуудад өргөн дэлгэр тэмдэглэжээ. Энэ баяр бол монголчуудын хувьд онцгой чухал ач холбогдолтой үйл явдал байв. Учир нь 1920-иод оны дунд үеэс хойш бараг 20 гаруй жил улс орны тусгаар тогтнол, аюулгүй байдалд заналхийлж байгаа хамгийн аюултай, заналт дайсан бол Япон хэмээн сурталчилж ирсэн тул тэрхүү дайсныг дарж устгаггүй цагт бид хэзээ ч амар тайван аж төрж чадахгүй гэсэн ойлголт монголчуудын оюун санаанд бат шингэсэн байв. Ялалтын баяр манай ард түмний урам зориг, эх оронч үзэл санааг сэргээж, ирээдүйд эх орондоо эзэн болж, айх аюулгүй, амар тайван амьдрах болно гэсэн итгэл найдварыг буй болгожээ. Ийм итгэлээр жигүүрлэсэн малчид, хөдөлмөрчид нам, засаг, хувьсгалт цэрэгтээ ялалтын баярын илэрхийлэлт болгон бэлгэр ирүүлсээр байв. Тухайлбал, Архангай аймгийн төвийн идэвхтэн эмэгтэйчүүд МАХН-ын Төв Хорооны нарийн бичгийн дарга Н.Янжмаад ялалтын баярын илэрхийлэлт ирүүлж, ах дүү Өвөр Монгол, Баргын ард түмэнд эрх чөлөө олгогч Монгол ардын хувьсгалт цэргийн хүчин чадлыг зузаатгахад зориулан 2337 төгрөг, сүлжмэл эдлэл, алтан эзэмг, бөж зэрэг бэлгэ ирүүлжээ. Аймгийн Намын Хорооны бичээч Янжинлхам, ажилтан Энэбиш, бага эмч Лхамхүү нар тус бүр гурван цэнгийн алтан эзэмг, бөж, нягтлан бодогч Батсүх хүүхдийнхээ хамт 350 төгрөг бэлэглэжээ. Ийм жишээ олныг дурдаж болно.

Ялалтын баярын дараахнаас Монгол ардын хувьсгалт цэргийн анги, салбарууд эх орныхоо зүг буцаж маршийн бэлтгэлийг эрчимтэй хийж, 9 дүгээр сарын 15-ны өдрөөс хүлгийн жолоог залан бараг сарын дараа байнгын байрлалдаа ирэв. Харийн дайсныг өвдөг сөгдүүлэн ялалт байгуулсан дарга, цэргүүдийг эх орон нь баяр хөөртэй угтав. Тухайлбал, Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар морьт дивиз 10 дугаар сарын 11-ний өдөр Байшинтад хүрэлцэн ирэхэд нам, төрийн төлөөлөгчид, цэргийн алба хаагчид, дарга нарын гэр бүл болон ардууд баяр хөөртэй угтан авч баярын цуглаан хийжээ. Дивизийн дарга, хурандаа Г.Дорж дивизийн бие бүрэлдэхүүнийг жагсаан Намын Төв Хорооны нарийн бичгийн дарга Н.Янжмаад "Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар морьт дивиз нь нам, засгийн даалгасан байлдааны үүргийг амжилттай биелүүлэн Японы эзэрхэг түрэмгий нарыг хоёр хөл дээр нь сөгдүүлж, зэвсгийг нь хураалгасан төдийгүй ах дүү Дотоод Монголын ард түмнийг чөлөөлж, хувьсгалт, тусгаар тогтносон Монгол Улсынхаа нэр алдрыг ихэд

мандуулсан"-ыг илтгэжээ. Дараа нь ялалтын баярын цуглаан болж, дайнд яваад ирсэн дарга нарын гэр бүлийг төлөөлөн дивизийн Намын ажлын зааварлагч, ахлах дэслэгч Пүрэвжавын эхнэр Пагма баяр хүргэж үг хэлсэн байна. Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар морьт дивизийн түүхэнд энэхүү баярт үйл явдлыг дүрслэн, "Энэ үед эмэгтэйчүүд нь дуулах баярлах ба хөгжмийн элшиг цуурайтан дуугарч, дайснаа дарсан 7 дугаар баатарлаг дивизийн байлдагч нарын баярын амьсгалыг тэнгэр, газарт багтахгүй болтол бадруулан байсан" бөгөөд орой нь "Дивиз ба ангиудын удирдлагын хамтарсан цайллага болж баярын хундага өргөж, ард түмэндээ гавьяа байгуулсан их ялалтыг илэрхийлэн инээдэм шуугиан болж байгаа нь манай эцэг өвгөдийн үүрдийн эрэлхэг дайчин эх оронч нарын уламжлал мөн болсныг үзүүлэв" гэжээ.

Чөлөөлөх дайн Монгол, Зөвлөлтийн цэргийн ялалтаар төгсөж, манай дарга, цэргүүд эх орон, ард түмнийхээ үүрэг, тушаалыг нэр төртэй биелүүлэв. Байлдааны ажиллагааг чадамгай удирдсан, гарамгай байлдсан Монгол ардын хувьсгалт цэргийн генерал, офицер, түрүүч, байлдагч 2300 гаруй хүнийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн дээд шагнал одон, медалиар шагнаж урамшуулснаас 500 орчим нь

офицер, бага дарга, цэргийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн одон, медалиар шагнажээ.

Монгол, Зөвлөлтийн армийн ялалтаар төгссөн Чөлөөлөх дайн бол зөвхөн Ази дахь дайны төгсгөл бус бүтэн зургаан жил үргэлжилсэн дэлхийн хоёрдугаар дайны төгсгөл болсон юм. Энэхүү дайн дууссанаар дэлхий дахинд энх амгалан байдал тогтож, олон улс орон тусгаар тогтнолоо тунхаглаж, хүн төрөлхтөн хөгжил дэвшлийн шинэ эрин үедээ орсон билээ. Чөлөөлөх дайны ялалт нь Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолыг хамгаалах, олон улсын тавцанд бататган бэхжүүлэх үйлсэд онцгой чухал ач холбогдолтой болсон юм.

Чөлөөлөх дайны ялалт нь манай улсын нийгэм, эдийн засгийн хөгжилд ч чухал түлхэц болсныг онцлон тэмдэглэх нь зүйтэй. Дайны төгсгөлөөр Барга, Өвөр Монголоос олон зуун айл өрх тус улсад нүүдэллэн ирснээр манай улсын хүн ам, эдийн засаг, нийгэм, шашин, соёл болон засаг захиргааны зохион байгуулалтад багагүй өөрчлөлт орсон нь үүний нотолгоо болно.

Чөлөөлөх дайны төгсгөлөөр Хөлөнбуйрын Барга болон Өвөр Монголоос БНМАУ-д ирсэн хүмүүсийг доорх хүснэгтээс харахад Бүгд Найрамдах Монгол Ард Улсад

| № | Хаанаас ямар зорилгоор ирсэн | Өрхийн тоо | Хүний тоо | Малын тоо |
|---|---|-------------|-------------|---------------|
| 1 | Шилийн голын чуулганы Үзэмчин хошуунаас Дорнод аймагт сайн дураараа нүүдэллэн ирсэн | 468 | 1785 | 33316 |
| 2 | Хөлөнбуйрын Шинэ Барга зүүн хошуунаас Дорнод аймагт сайн дураараа нүүдэллэн ирсэн | 234 | 1013 | 51090 |
| 3 | Шилийн голын чуулганаас Сүхбаатар аймагт сайн дураараа нүүдэллэн ирсэн | 561 | 1613 | Тодорхойгүй |
| 4 | Өвөр Монголоос Дорноговь аймагт нүүдэллэн ирсэн | 502 | 1743 | 49257 |
| | Нүүдэллэн ирсэн бүх өрх, ам | 1765 | 6154 | 133663 |
| 4 | Бүгд Найрамдах Монгол Ард Улсад суралцахаар ирсэн | - | 214 | |
| 5 | Бүгд Найрамдах Монгол Ард Улсад ажиллахаар ирсэн | | 1078 | |
| 6 | Бүгд | 1765 | 7446 | 133663 |

Байлдааны гавьяаны улаан тугийн одон хүртжээ. Тулалдааны талбарт баатарлагаар байлдаж амь үрэгдсэн Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар хуягт бригадын пулемётчин Л.Аюуш, баатарлаг байлдсан С.Дампил, миномётчин Д.Данзанваанчиг нарыг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн 1945 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн тогтоолоор БНМАУ-ын Баатар цолоор шагнажээ. Хожим нь 7 дугаар Хуягт бригадын дарга Д.Нянтайсүрэн, салааны дарга Т.Дүүдэй, холбоочин М.Жанчив нарыг мөн БНМАУ-ын Баатар цолоор шагнасан юм.

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар Монгол ардын хувьсгалт цэргийн 302 генерал, офицерыг одон, медалиар шагнасан бол Зөвлөлтийн Улаан армийн 513 генерал,

1765 өрхийн 6154 хүн орж ирсний 600 орчим өрхийн 2000 орчим хүн нь 1931-1932 онд эх орноосоо дүрвэн гараад буцаж ирэгсэд, бусад нь амьдрах зорилгоор шинээр нүүж ирэгсэд байжээ. Барга, Өвөр Монголоос олон зуун айл өрх Монгол Улс, монгол үндэстнийхээ гал голомтыг зорин нүүж ирсэн нь БНМАУ-ын хүн ам, мал сүргийн тоо толгойн өсөлт, угсаатны бүлгийн харьцаа, эдийн засаг, соёлын хөгжилд зохих түлхэц болсон билээ. Тэд Монгол Улсдаа ирээд эх орныхоо хөгжил дэвшлийн төлөө үнэнч шударгаар хөдөлмөрлөж, дундаасаа алдар суутай цөөнгүй хүмүүсийг төрүүлсэн юм. Барга, Өвөр Монголчуудын монголоо зорьсон нүүдэл бол үндэснийхээ эв нэгдэл, тусгаар тогтнол, хөгжил дэвшлийн төлөөх тэмцэл байв.

Доктор (Ph.D), профессор, бэлтгэл хурандаа Г.МЯГМАРСАМБУУ

5 ДУГААР МОРЬТ ДИВИЗИЙН ДАЙНД ОРОЛЦСОН ТҮҮХЭЭС ...

Дэлхийн хоёрдугаар дайны бүхий л явцад Монголын ард түмэн, түүний Зэвсэгт хүчний дайчид хүн төрөлхтний нэгэн адил аюулт дайныг аль болох түргэн дуусгахыг хүсэн хүлээж байсан юм. Улмаар Фашистын Герман Өрнөдөд бууж өгч, холбоотон гүрнүүд Японы эсрэг дайныг Алс Дорнодод явуулах, түүнтэй холбоотой олон асуудлаар, түүний дотор Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тусгаар тогтнолын асуудлаар зарчмын тохиролцоонд хүрсэнд туйлын баяртай байлаа.

Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улс болон Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газрын хооронд Чөлөөлөх дайнд Монгол ардын хувьсгалт цэргийн анги, нэгтгэлүүдийг оролцуулах, "Морьт механикжуулсан бүлэг"-ийг байгуулан түүний Ерөнхий командлагчаар маршал Х.Чойбалсан, орлогчоор нь Ж.Лхагвасүрэн, И.А.Плиев нар томилогдож Монгол ардын хувьсгалт цэргийн нэгтгэл, ангиуд байлдааны тушаал хүлээн авч, үүрэг гүйцэтгэхэд бэлэн болсон байна.

Чөлөөлөх дайнд 5 дугаар морьт дивиз 1945 оны 7 дугаар сарын 5-ны өдөр байнгын байрлалаасаа хөдлөн 355 километр газар марш үйлдэж Дарьгангын Молцог элс хэмээх газар хүч хуралдуулан байрласан юм. Тус дивизийн даргаар ардын хувьсгалын партизан, хошууч генерал Ч.Доржпалам, улс төрийн хэлтсийн даргаар дэд хурандаа Н.Лувсанлхүндэв, штабын даргаар дэд хурандаа Н.Дугаржав, М.Чимид, 13 дугаар морьт хорооны даргаар Л.Дандар, 14 дүгээр морьт хорооны даргаар П.Жамбал, 28 дугаар морьт хорооны даргаар Ж.Рэнцэн, их



Дивизийн дарга, хошууч генерал Ч.Доржпалам маршал Х.Чойбалсанд илтгэл өгч байгаа нь

бууны хорооны даргаар Н.Гомбожав, хуягт дивизионы даргаар Н.Чүлтэм нар томилогдон Чөлөөлөх дайнд оролцжээ.

Морьт механикжуулсан бүлэг Хаалганы чиглэлд Улаан армийн анги, нэгтгэлүүдтэй харилцан ажиллагаатайгаар Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар хуягт бригад, 3 дугаар их бууны хороо, Долоннуурын чиглэлд Улаан армийн анги, нэгтгэлүүдийн хамт Монгол ардын хувьсгалт цэргийн 5, 6, 7, 8 дугаар морьт дивиз, 3 дугаар танкийн хороо, холбооны хороо тус тус үүрэг гүйцэтгэсэн ажээ.

Монгол ардын хувьсгалт цэргийн 5 дугаар морьт дивиз бусад нэгтгэл, ангиудын хамт 1945 оны 8 дугаар сарын 9-ний өдөр улсын хилийг давж, хоногт 60 км/цагийн хурдтайгаар давшин 6 дугаар морьт дивизийн хамт Губейкоу сууриньг эзлэн авсан байх тушаал хүлээн авчээ. Фронтын тухайн цагийн байдал нь Японы зүгээс Зөвлөлт-Монголын Морьт механикжуулсан бүлгийн эсрэг эсэргүүцэл үзүүлэх чадваргүй болсон тул 5 дугаар морьт дивиз 10-15 хоногт 1000-

1100 километр замыг туулан 8 дугаар сарын 21-ний өдөр Губейкоу сууриньг бүрэн эзлэн авчээ.

Тус дивизийн 28 дугаар хорооноос Толгойн сэргийлэхэд гарсан салааны дарга Халцгайн Хүүхээ 8 дугаар сарын 21-ний өдрийн үүрээр Японы 32 цэрэг, найман офицерыг, хорооны дарга Ж.Рэнцэн, сургагч И.В.Гаврилов нарын удирдсан анги "Цагаан хэрэм"-д бугшиж байсан 1231 яоныг дарга нарынх нь хамтаар буулган авсан тухай баримтууд нь хадгалагдсан байдаг.

Энэ үед генерал Ж.Лхагвасүрэн, Ч.Доржпалам нар хүрэлцэн ирж нөхцөл байдалтай танилцаад Губейкоу сууриньг комендантээр 13 дугаар морьт хорооны дарга, улсын баатар Л.Дандарыг томилжээ. 5 дугаар морьт дивиз Японы цэргийн есөн агуулахыг эзлэн авсны дөрөв нь зэвсгийн агуулах байсан бөгөөд тэрхүү зэвсгийг Хятадын ардын чөлөөлөх армид хүлээлгэн өгсөн ба үлдсэнийг нь устгажээ.

Монгол ардын хувьсгалт цэргийн нэгтгэл, ангиудын байлдааны ажиллагаа явуулсан

зурваст, түүний дотор 5 дугаар морьт дивизийн зурваст Японы талаас зохион байгуулалттай эсэргүүцэл үзүүлсэн цаг үе байсан хэдий ч 1945 оны Чөлөөлөх дайн бол Монгол ардын хувьсгалт цэргийг үеийн үед дурсагдах түүхэн гавьяа баатарлаг үйл явдлаар баяжуулсан юм.

Монгол ардын хувьсгалт цэргийн үндсэн анги, нэгтгэлүүдийн байлдааны ажиллагаа явуулсан зурваст бол уртаараа 500 километр, өргөнөөрөө 250 километр газрыг хамарч байлаа. Цахарын их элсэн цөлийг аагим халуунд хоногт 80-100 километр газрыг туулж чадсан нь Монгол ардын хувьсгалт цэргийн ангиуд байлдааны үүргээ байгаль, цаг уурын ямар ч нөхцөлд биелүүлэх чадвартай, цэрэг дайчид нь хосгүй их тэсвэр хатуужилтайг илтгэн харуулсан юм. Дайны халуун цэгт аагим халуун, аадар бороо, гол мөрний үер усны аюул, их элсэн цөл нь монгол цэргийн зоригийг мохоож чадаагүй бөгөөд үүгээр Монголын Зэвсэгт хүчин зүй ёсоор бахархан санан дурсах учиртай.

1945 оны 9 дүгээр сард Морьт механикжсан бүлгийн командлагч, маршал Х.Чойбалсан, түүний орлогч Ж.Лхагвасүрэн нар Губейкоу сууринд түр байрлаж байсан хошууч генерал Ч.Доржпалам даргатай 5 дугаар морьт дивизийн байрлалд хүрэлцэн ирсэн ба Чөлөөлөх дайнд тус дивизийн гүйцэтгэсэн байлдааны үүргийг өндөрөөр үнэлэн байлдаанд шалгарсан тэргүүний нэгтгэл, ангиудад олгодог "Дурсгалын туг"-ийг гардуулжээ.

Дурсгалын туг гардуулах ёслолд оролцсон ахмад дайчин Б.Сааралдай дурсан ярихдаа "Маршал Х.Чойбалсан 5 дугаар морьт дивиз Чөлөөлөх дайнд тавигдсан үүргийг амжилттай биелүүллээ. Энэ хэрэгт дивизийн манай

цэргийн авьяаслаг дарга, ардын хувьсгалын партизан, генерал Ч.Доржпалам дивизийн байлдааны ажиллагааг сайн удирдлаа гэдэг нийт бүрэлдэхүүнд баяр хүргэж байсан" гэжээ. Ингэснээр 1945 оны 9 дүгээр сарын 15-ны өдөр 5 дугаар морьт дивиз Губейкоу сууриньгаас эх орныхоо зүг марш үйлдэн 10 дугаар сарын 5-ны өдөр байнгын байрлалдаа ирсэн түүхтэй.

1939 оны Халх голын байлдаанд 5 дугаар морьт дивизийг командалж явсан хурандаа Гэндэнгийн Дорж, 1945 оны Чөлөөлөх дайнд 5 дугаар морьт дивизийн захирагч, хошууч генерал Ч.Доржпалам, 13 дугаар морьт хороог командалж оролцсон домогт баатар, хурандаа Лодонгийн Дандар, дайны дараах жилүүдэд 5 дугаар бригадын даргаар ажиллаж байсан төр, цэргийн нэрт зүтгэлтэн, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар, армийн генерал Батын Дорж, энхийн бүтээн байгуулалтын үед Барилгын 5 дугаар батальоны даргаар ажиллаж байсан домогт хилчин Бүгд Найрамдах Монгол Ард Улсын баатар Пунцагийн Чогдон, 1980-1990-ээд оны Ардын Армийг өргөтгөн зохион байгуулах үед 5 дугаар мотобуудлагын дивизийн захирагчаар ажиллаж байсан хошууч генерал Ж.Дашзэвэг, Улсын Бага хурлын гишүүн, хошууч генерал Ч.Цэрэндагва нарын алдартнуудаар бид бахархаж, тэдний бахдам гавьяа, түүхэн алдрыг хойч үедээ өвлүүлэн сурталчлах нь бидний үүрэг хэмээн үзсээр байна.

Монгол цэргийн түүхэн дайчин уламжлал үүрд мандан бадрах болтугай.

"Их уул цэргийн хүрээ" ТББ-ын Гүйцэтгэх захирал, бэлтгэл хурандаа Д.ПҮРЭВДОРЖ



ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

“Монголчуудын түүх бол монгол цэргийн түүх” хэмээсэн онц үгийг бид байнга хэрэглэх болжээ. Үнэхээр ч олон зууны түүхтэй Монгол орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын төлөө үеийн үед баатарлагаар тэмцэж, бахдам гавьяа байгуулсан цэрэг эрсээрээ бахархаж буй нэгэн баталгаа нь дээрх үг биз ээ. Түүхийн шаргал хуудаснаа нэр нь мөнхөрсөн мянга мянган эх орончид, цэрэг эрс байдгийн дотор гэр бүлээрээ, ах дүүсээрээ цэргийн албыг нэр төртэй хааж, дайны талбарт ч, даян дэлхийн энхийн үйлт ч, энх цагийн хөгжил дэвшил, бүтээн байгуулалтад ч өөрийн нэр алдраа цуурайтуулсан эх орны хүү, эгэл цэргийн гавьяаг хойч үеийнхэн мартаж учиргүй.

Саяхан сонины редакад Ховд аймгийн Манхан сумын харьяат, бэлтгэл хурандаа Жамбын Нямдаваа зочилж, сонин, сэтгүүлийн нийтлэлийн бодлого, үйл ажиллагааны талаар санал солилцох зуураа өөрийнх нь төрсөн сумаас Халхын голын байлдаанд болон Чөлөөлөх дайнд оролцож явсан ах, дүү гурвын талаар сонирхолтой яриаг өрнүүлсэн. Тэрхүү ярианд тулгуурлан Батлан хамгаалахын төв архивын лавлагаа, ахмад дайчны өөрийн болон төрөл садны дурсамжид тулгуурлан Ө.Найдан, Ө.Бугалжаа, Ө.Ламсан нарын тухай нийтлэл бичиж уншигч танд хүргэхийг зорьсон минь энэ.

“БАЙШИНТЫН ДИВИЗ”-ЭЭР ОВОГЛОСОН ДАЙЧИН

“Байшинтын” хэмээн алдаршсан 7 дугаар морьт дивизээс амьдралын гараагаа эхлэн цэргийн холбоочин болж 1945 оны Чөлөөлөх дайнд оролцон байлдааны үүргээ нэр төртэй биелүүлсэн бөгөөд алдар түүхийн дайчин замналтай Зэвсэгт хүчний 013 дугаар анги болон Улаанбаатар төмөр замын байгууллагад залуу халуун насаа амжилт дүүрэн өнгөрүүлсэн Ховд аймгийн уугуул, чөлөөнд байсан ахмад Өлзийн Найдангийн талаарх архивын баримт, ахмад дайчдын дуртгалаас үзэхэд түүний амьдрал энгийн агаад ихэд сонирхолтой ажээ. Тэр бээр Засагт хан аймгийн Баатархайрхан уулын Захчин гүний хошуу буюу одоогийн Ховд аймгийн Манхан сумын “Цагаан гол” хэмээх газар 1914 оны хөх бар жил ард Өлзийгийн ууган хүү болж мэндэлжээ. Энэхүү нутгийн уугуул Өлзий нь Найдан, Бугалжаа, Ламсан нарын хүү, Тож, Цэнд нарыг төрүүлж өсгөсөн гавьяатай нэгэн ажээ.

Ө.Найдан нь бага балчир наснаасаа мал маллан өртөөний галч, улаач, зарлага зэрэг албыг залгуулж байгаад 1935 оны 10 дугаар сард цэргийн албанд мордож Хэнтий аймагт байрлах 7 дугаар морьт дивизийн 20 дугаар морьт хороонд жагсаалын цэргээр алба хааж эхэлсэн. Тэр бээр бие даан бичиг үсэгт суралцаж, улмаар 1936 оны хавар 20 дугаар морьт хорооны бага даргаар дэвшин ажиллаж байгаад 1937-1939 онд Зөвлөлт Холбоот Улсын Киев хотноо И.М.Калининийн нэрэмжит Холбооны дунд сургуульд Г.Сугар, Д.Лхамсүрэн, Д.Пунцаг, Г.Дамдинсүрэн, В.Бат, У.Пэрэнлэйлхүндэв, Д.Шархүү, Ц.Ванчинсүрэн, Н.Удвал, Л.Нямжав, Ж.Гомбосүрэн, Д.Цогт, Б.Дамбадаржаа, Б.Тунсаг нарын 14 сурагчийн хамт суралцаж төгссөн байна. Ө.Найдан нь Цэргийн Явдлын Яамны сайд, Бүх цэргийн жанжны орлогчийн 1939 оны 11 дүгээр сарын 4-ний өдрийн 226 дугаар тоот тушаалаар Холбооны тусгай хороо (өнөөгийн Зэвсэгт хүчний 013 дугаар анги)-ны Шугам барилгын суманд дэслэгч цолтой, салааны даргаар томилогджээ.

Тухайн үед Улсын батлан хамгаалах комиссын 1936 оны 2 дугаар сарын 28-ны өдрийн хурлаар Дорнод хязгаарыг Чита хоттой байнгын радио холбоогоор хангах үүрэгтэйгээр Цахилгаан мэдээний ба Агаарын байнгын шугам болох телефон холбооны тусгай дивизионыг 1942 онд байгуулсан ба 1944 оноос Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн газраас дайчилгааг төлөвлөх, улсын нөөцийг бий болгох ажлыг эрхлүүлсэн. Улс орныг дайнд бэлтгэх ажлыг эрчимжүүлж эхэлсэнтэй холбогдуулан Байшинт дахь Армиин ханган нийлүүлэх бааз, хээрийн госпиталиуд, Өндөрхаан-Сайншанд, Байшинт-Сайншанд, Байшинт-Чойр, Сайншанд-Замын-Үүд, Сайншанд-Сулинхээрийн чиглэлд усны эх ундаргыг

сэргээн засах, шинээр хайж олох, Сайншанд, Байшинтын районы гол чиглэлүүдэд хээрийн хориглолтын заагууд мөн Сайншандад Армиин холбооны зангилгаа байгуулах ажлыг амжилттай гүйцэтгэсэн түүхтэй. Үүнд: Замын-Үүд, Өлгий хийд, Байшинтын нэгтгэл, ангиуд, зүүн Чойрын хоорондох холбооны шугамыг байнгын ажиллагаатай байлгах, гэмтэл гарсан тохиолдолд цаг алдалгүй засварлах ажлыг дэслэгч Ө.Найдан даргатай холбоо салааны бие бүрэлдэхүүн гүйцэтгэсэн нь түүхэнд

зүйн хэрэг.

Дайн дууссаны дараа салааны дарга, дэслэгч Ө.Найдан нь Цэргийн Явдлын Яамны сайд, Бүх цэргийн жанжны орлогчийн тушаалаар 1946 оны хавраас 6 дугаар морьт сумангийн жагсаал ангийн орлогчоор, 1948-1949 онд 6 дугаар морьт дивизэд их бууны холбооны даргаар, 1949-1951 онд Цэргийн ерөнхий сургуулийн холбооны багшаар томилогдон цэрэг, армитай 16 жилийн амьдралаа холбосон ахмад дайчдын нэг юм.

байлдагчдын жагсаалтын 49-д бичигдсэн ба нэн тэргүүний дайчин гэгдэж байсан дурсамж түүний намтарт мөнхрөн үлджээ. Тодруулбал, сум шунгинан исгэрч, бөмбөг дэлбэрч байсан ч байлдааны цагийн тушаалыг ямар ч үед сайн гүйцэтгэж, амьд хэл олныг барьсан тул дайны фронт дээр Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулсан цөөхөн цэргийн алба хаагчдын нэг нь Ө.Бугалжаа байсан юм. Түүний байгуулсан гавьяа удах тусам үнэлэгдэн Халхын голын ялалтын

тухай түүний бага охин Л.Дашмаа дурссан.

Ө.Ламсанг балчир байхад түүний эцэг Өлзий нь 37 насандаа өвчний учир хорвоог орхисноор хар нялхаараа өнчирч хоцорсон ч эхийн хайр, ах, эгчийнхээ ивээлээр хүний зэрэгт өсөж торнин 18 насандаа цэргийн албанд татагдсан юм. Тэр Ховдын хороонд цэргийн албаа хааж Ховдоос Улаанбаатар хот руу мориор явсан гэх ба улмаар Матадын 8 дугаар дивизийн их бууны ангид хуваарилагджээ. Ийнхүү цэргийн


АЛДАР НЬ ДУРСАГДАХ АХ ДҮҮГҮРАВ



Өлзийн НАЙДАН



Өлзийн БУГАЛЖАА



Өлзийн ЛАМСАН

тэмдэглэгдэн үлджээ.

Тэрээр 1945 оны 5 дугаар сараас Байшинтын 7 дугаар морьт дивизэд холбоо сумангийн даргаар томилогдон ажиллах болсон бөгөөд дивизийн даргаар хурандаа Г.Дорж (1942.6.5-1945.12.7), штабын даргаар дэд хурандаа Д.Самданлхүндэв (1942.8-1945.10.25), улс төрийн хэлтсийн дарга бөгөөд улс төрийн орлогчоор дэд хурандаа Г.Вандан (1945-8.2-1946.2.8) нар ажиллаж байв.

Тэр хугацаанд Ази тивд түрэмгийлэл үйлдэж байсан Японы цэргийн ноёрхлыг няцааж, Өвөр Монголын ард түмнийг чөлөөлөх, тэрхүү дайнд бэлтгэх ажил Монгол ардын хувьсгалт цэргийн хувьд 1945 оны 5 дугаар сарын дунд үеэс өрнөсөн ажээ. Монгол-Зөвлөлтийн Морьт механикжуулсан бүлгийн бүрэлдэхүүнд Монгол ардын хувьсгалт цэргийн дөрвөн морьт дивиз, нисэх дивиз болон моторжуулсан хуягт бригад, танк, артиллери, холбооны хороо, байлдааны хангалтын салбарууд багтсан бөгөөд эдгээр анги, нэгтгэлүүдийг Замын-Үүд, Байшинт гэсэн хоёр чиглэлд хүч хуралдуулах ажлыг зохион байгуулсан.

Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар морьт дивиз нь цэргийн дээд удирдлагаас өгсөн байлдааны тушаалын дагуу 8 дугаар сарын 7-ны өдөр Байшинтын районоос Долооннуур (Долоон нуур), Жэхэ (Чэндэ) гэсэн маршрутаар 950 километр давших байлдааны үүргийг хүлээж 8 дугаар сарын 8-ны өдөр Овоотоос марш үйлдэн хилийн районд хүчээ хуралдуулан 9-ний өдрийн 04.00 цагт улсын хилийг давсан ба дайсныг гэнэдүүлэх зорилгоор артиллери, авиацийн бэлтгэлийг хийлгүйгээр давшин байлдаж, дээд удирдлагаас өгсөн байлдааны үүргээ амжилттай биелүүлсэн юм.

Чөлөөлөх дайны үед цэргийн нэгтгэл, (11АК-1, 5АК-6 нийт 7 радиостанц) анги, хороод гол төлөв радио болон хөдөлгөөнт утас холбоог өргөн ашиглаж байсан ба цаг агаарын нөхцөл байдалаас шалтгаалан радио станцуудын хэвийн ажиллагаа алдагдаж байсан учир холбоочид шөнийн цагаар жижүүрлэх, 11 АК, 5 АК радиостанц (буудал), онгоц, хөнгөн хуягт, суудлын авто машин, мотоцикл зэрэг техник хэрэгслээр холбооны бэлэн байдлыг ханган ажиллаж байв. Энэхүү нэн хариуцлагатай үүргийг амжилттай биелүүлэхэд цэргийн холбоочид, түүний дотор Ө.Найдангийн хувь нэмэр ихээхэн байсныг онцлох нь

Энх цагийн бүтээн байгуулалтын үед тэрээр 1951-1952 онд Улаанбаатар хотын Төв бараа баазад ачигч, 1952-1961 онд Улаанбаатар төмөр зам нийгэмлэгийн Дохиолол холбооны албанд аккумуляторчин, холбооны жижүүрийн механикч, 1961 оноос Төмөр замын нийгэмлэгийн Дохиолол холбооны албаны харьяа Төв аймгийн Баян сум дахь Мааньт өртөөнд холбооны ахлах техникчээр тус тус ажиллажээ.

Чөлөөнд байсан ахмад Ө.Найданг 1945 оны Чөлөөлөх дайнд үүргээ нэр төртэй биелүүлсэн, энх цагийн бүтээн байгуулалтад залуу төмөр замчин болон холбоочдыг бэлтгэх, сурган дадлагажуулах ажилд онц идэвх зүтгэл гаргасныг нь төр, засгаас өндөрөөр үнэлэн 1945 онд Монгол-Зөвлөлтийн “Бид ялав” медаль, 1951 онд “Алтан гадас” одон, 1946 онд Байлдааны хүндэт медаль, Ардын хувьсгалын 25 жилийн ойн медаль, 1956 онд “Алтан гадас” одон, 1961 онд Ардын хувьсгалын 40 жилийн ойн медаль, 1981 онд Ардын хувьсгалын болон Зэвсэгт хүчний 60 жилийн ойн медалиар тус тус шагнажээ. Мөн дайнд оролцож явсныг нь өндөрөөр үнэлэн тухайн үед Батлан хамгаалах яамны сайд асан хурандаа генерал Ж.Ёндон Байлдаанд оролцогчийн үнэмлэх, тэмдгийг нь өөрийн биеэр гардуулан өгчээ. Ө.Найдан төмөр замын салбарт 24 жил тасралтгүй ажиллаад 1975 онд гавьяаныхаа амралтад гарсан ажээ. Тэр бээр Дундговь аймгийн харьяат Балдангийн Лхамсүрэнтэй 1948 онд гэр бүл болж хувь заяагаа холбосон бөгөөд өнөөдөр тэдний охин Н.Зина, хүү Н.Даваасүрэн, охин Н.Бийширмаа нар нь мэргэжил эзэмшиж, эх орныхоо хөгжил дэвшилд өөрсдийн хувь нэмрээ оруулсаар яваад нь талархал илэрхийлэе.

ХАЛХЫН ГОЛД ХАТУУЖСАН ХАТАН ЗОРИГТНЫ НЭГ СЭН

Ховд аймгийн Манхан сумын харьяат Өлзийн удаах хүү Бугалжаа нь тус сумын Баянгол хэмээх газар 1916 оны гал луу жил мэндэлжээ. Тэр бээр нутагтаа мал маллаж амьдарч байгаад 23 насандаа цэрэгт татагдан 1939 оны Халхын голын байлдаанд оролцон өөрийн эх орноо харийн дайснаас батлан хамгаалах ариун үүргээ шударгаар биелүүлсэн зоригт дайчдын нэг юм.

Энэхүү Халхын голын байлдаанд тэр бээр их бууны наводчик, тагнуулын ахлагч албан тушаалтайгаар гарамгай

30, 40, 50 жилийн ойн баярт зориулсан ёслолын ажиллагаанд уригдан оролцсон аж. Дайны талбарт амь үрэгдсэн дайчин нөхдийнхөө гэгээн дурсгалыг хүндэтгэн цэцгийн мандлаар харууслаа илэрхийлэхдээ “Дайн гэдэг хэчнээн аймшигтай, дарийн утаа дахин бүү үнэртээсэй” хэмээн харуусан толгой гудайн зогссон тухайгаа хуучлан дурсамжаа үлдээжээ.

Дайн дуусаж, дарийн утаа эх орны минь хөх тэнгэрээс замрах даруй өөрийн төрж өссөн нутаг, төрүүлж өсгөсөн ээж, дүү нартаа эргэн очиж, өнөр гэр бүлтэй болсон ба энх цагийн хөдөлмөрт хүчин зүтгэжээ. Ө.Бугалжаа нь сум, багийн дарга, сумын нарийн бичгийн дарга, сургуулийн комендант, “Баясгалант амьдрал” нэгдлийн тариа бригадын даргаар олон жил үр бүтээлтэй ажиллаж, үлгэр жишээчээр хөдөлмөрлөсөн тухай Манхан сумын ойд зориулсан дурсамжийн номд бичжээ. Түүний ажилласан жилүүдэд Хар усны тарианы талбайгаас га тутмаас нь 14-16 центнер ургацыг хурааж нэгдлийн эдийн засгийн чадавхыг нэмэгдүүлэх, нэгдлийн гишүүдийн аж амьдралыг дээшлүүлэхэд ихээхэн үүргийг гүйцэтгэсэн ажээ. Тэр бээр удирдан зохион байгуулах ажлын арвин туршлагатай, алия хошин, угийн дуу цөөтэй ч дайн гэж юу болох, үхэл хагацал, өнчрөл харуусал гэж юу байдгийг Халхын голын байлдааны үеэр мэдэрсэн бөгөөд үр хойч, залуустаа сургаал, сургамжаа хайрлан тэдэнд эх оронч үзэл, хүмүүжлийг төлөвшүүлэх үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулсаар ирсэн нь бахдалтай.

Дайны талбарт ч, энхийн хөдөлмөрт ч түүний байгуулсан эрхэм гавьяаг төр, засгаас өндөрөөр үнэлэн Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн цол хүртээж, Монгол-Зөвлөлтийн “Бид ялав” медаль, Улс, Хувьсгалын болон Халхын голын байлдааны ойн медалиудаар шагнаж байжээ.

ДАЙНЫ ТАЛБАРТ АХТАЙГАА УУЛСАН ДАЙЧИН ТҮҮХТЭЙ

Нутгийн ард олон Майдар эргэх гээд явчихсан үед ээж нь ганцаараа байхад гэнэт өвдөж Ардын хувьсгалтай эн чацуу Ө.Ламсан төрсөн аж. Тухайн үед хаанаас ирсэн нь үл мэдэгдэх хоёр орос түүнийг эх барин авчээ. Ингээд орос хүн эх барьж авсан болохоор нь Орсоо гэдэг нэр өгсөн боловч айлгаад болохгүй болохоор нь нутгийн нэгэн номтой лам дээр очиход “Нэр нь таараагүй” гэснээр Ламсан хэмээх нэрийг хайрласан

алба хаах хугацаандаа Чөлөөлөх дайнд оролцон Жанчхүүгийн даваа, Жэхэ хот, Долоннуур хүртэл дайтаж явсан ахмад дайчин байжээ.

Ө.Ламсан дурсамждаа “Дайсан ч гэлээ, хүний өөдөөс буу шагайх ч бас эвгүй. Нэг хоёрыг цааш нь харуулсны дараа л зориг ордог юм билээ ...” хэмээн бичиж, дайны хүнд хэцүү үеийн тухай нутгийн хүүхэд, залууст байнга харамсан ярьдаг байжээ. Түүний эх орныхоо төлөө тэмцэж, энхийн цагт хөдөлмөрлөж явсныг нь үнэлж Монгол-Зөвлөлтийн “Бид ялав” медаль, Халхын голын байлдааны ялалтын болон Ардын хувьсгалын ойн медалиудаар шагнасан бөгөөд тэрээр сумын аварга малчин, аймгийн хошой аварга малчин, аймгийн алдарт уяач цолыг хүртсэн эрхэм юм.

Хожим Ө.Ламсан багийн агент, хэсгийн ахлагч, “Баясгалант амьдрал” нэгдэлд хоньчин, тэмээчнээр тасралтгүй 34 жил ажиллажээ. Тэрээр хурдан жороо морь уяж, уралдуулах авьяастай, шатар их тоглодог, найраг уртын дууг сайхан дуулдаг, эр хүний бүхий л сайхан шинжийг өөртөө агуулсан эрхмийн дээд эгэл хүмүүн байжээ. Мөн хурдан морийг шинжихдээ нутаг усандаа гаргууд нэгэн бөгөөд түүний уясан хүлгүүд нь сум, аймгийн наадамд олон ч түрүү, айраг авсан. Тэрчлэн түүний заавраар хурдан морь уяж эрдэмд суралцсан олон уяачид бий шүү хэмээсэн охидынх нь дурсамжийг дэлгэн суугаа минь энэ билээ.

Энд нэгэн түүх сөхөхөд, Ө.Ламсан Чөлөөлөх дайнд оролцож явахдаа өөрийн том ах Ө.Найдантайгаа уулзах хувь тохиолдсон боловч ах нь: “Өөрийнхөө суманд өртүүзэй, сахилга хариуцлагатай байдаг юм шүү” гэж хэлээд явахад нь ихэд гомдож байсан тухай хуучилжээ.

Ийнхүү өөрийн эх орныхоо эрх чөлөө, тусгаар тогтнолыг батлан хамгаалах үйл хэрэгт жинтэй хувь нэмэр оруулан дайн, байлдааны талбарт өсгөрөх сум, тэсрлэг бөмбөгийг исгэрч, эрэлхэг зоригтой байлдсан Ө.Найдан, Ө.Бугалжаа, Ө.Ламсан нарын ахан дүүс шиг нэр нь тодроогүй дайчин эрс олон бий. Тэдний эх орон, элгэн садан, хайртай бүхнийхээ төлөө амиа ч үл хайрлан тэмцэж явсан баатарлаг үйлсийн түүхийг бид хэзээ ч мартажгүй бөгөөд тэднийгээ өнө мөнх дурсаж, үүрд мөнхжүүлэх учиртай.



ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ СОНИНООС ...

Шинжлэх ухааны академийн түүх, угсаатны зүйн хүрээлэнгийн салбарын эрхлэгч, доктор (Ph.D), профессор, бэлтгэл хурандаа Г.Мягмарсамбуу
Чөлөөлөх дайны түүхийг тусгайлан судалж, шинэхэн бүтээл туурвихаар ажиллаж байгаа юм. Түүний бичсэн өгүүлүүдийг бид сонсны сүүлийн дугааруудад оруулан уншигчдынхаа хүртээл болгож буй билээ. Энэ удаа түүний бүтээлд орсон Чөлөөлөх дайны үеийн зарим сонирхолтой баримтуудаас Та бүхэнд сонирхуулж байна.

“ТАГНУУЛЫН ТУСГАЙ БҮЛЭГ” БУЮУ ШИЛДГИЙН ШИЛДЭГ МОНГОЛ ЦЭРГҮҮД

Монгол, Зөвлөлтийн арми давшилтад орохын өмнө буюу 1945 оны 8 дугаар сарын 9-ний шөнө дунд тагнуулын тусгай бүлэг хил давжээ. Тэд нэн түрүүнд хил орчим байсан Японы салбаруудын утсан харилцааг тасалж, гэнэтийн дайралтаар бут цохин гол хүчний давшилыг хангах, Морьт механикжуулсан группийн удирдлагыг дайсны тухай мэдээгээр хангах үүрэгтэй байв. Дайн эхлэхээс хэдхэн хоногийн өмнө Дарьгангын Овоотод зохион байгуулж, тусгайлан сургасан Тагнуулын тусгай бүлгийг М.Д.Чернозубенко удирдаж байв. Уг бүлэгт Ц.Гочоогийн удирдсан орон нутгийн байдлыг сайн мэддэг, шилдгийн шилдэг долоон монгол цэрэг багтажээ. Тагнуулын бүлэг хүний тоогоор цөөн боловч зэвсэглэл маш сайн, найдвартай техник хэрэгслээр хангагдсан байв.

Тус бүлэг давшилын явцад гол хүчнээсээ ямагт 50-70 км түрүүнд давшин 50-60 км өргөн фронтод үүрэг гүйцэтгэж, замд тааралдсан дайсны бүх эсэргүүцлийг тас цохин, гол хүчнийг давшихад саадгүй болгон давшилын зурвас дахь нөхцөл байдлын тухай мэдээг группийн удирдлагад шуурхай хүргэж байв.

“Шилдгийн шилдэг” тагнуулчдаас гадна ЦЯЯ-ны Тагнуулын хэлтсийн дарга, дэд хурандаа Н.Баасан, туслах, хошууч Ч.Ишдорж, ахмад Д.Цэрэнжав болон анги, нэгтгэлийн олон тагнуулчид Чөлөөлөх дайнд оролцожээ.

Байлдааны тэргүүн шугамд тусгай үүрэг гүйцэтгэж, дайны ялалтад үнэтэй хувь нэмэр оруулсан тагнуулын бүлэг, “шилдгийн шилдэг” тагнуулчдынхаа тухай цаашид нягтлан судлах шаардлагатай байна. Цэргийн тагнуулчдын үйл ажиллагаа нь нууц байдалд явагддаг, тэдний ажиллагаанд холбогдох баримтуудыг нууцалж байсан зэргээс шалтгаалан түүхэнд тагнуулчдын гүйцэтгэсэн үүрэг өнөөг хүртэл бүдэг, бүрхэг хэвээр байсаар байна.

ТУЛАЛДААНЫ ТАЛБАРТ БААТАРЛАГААР АМЬ ҮРЭГДСЭН ДАЙЧИД

Жанчхүүгийн даваанд хамгийн ширүүн тулалдаан явагдсан 8 дугаар сарын 19-ний өдрийн байлдаанд Монгол ардын хувьсгалт цэргийн есөн цэргийн албан хаагч амь үрэгдэж, 8 дугаар сарын 19-20-ны өдрийн байлдаанд 22 цэрэг шархаджээ. Тулалдаанд баатарлагаар амь үрэгдсэн дайчид нь:

1.Хуягт батальоны жолооч Галсангийн Чулуунбат. Архангай аймгийн Хан-Оюут (өнөөгийн Их Тамир) сумын харьяат, 26 настай, 1939.06.10-ны өдөр цэрэгт ирсэн,

2.Телефончин Магсарын Жанчив. Говь-Алтай аймгийн Хасагжаргалан (өнөөгийн Шарга) сумын харьяат, 24 настай, 1940.06.15-ны өдөр цэрэгт ирсэн,

3.Хөнгөн пулемётын наводчик Манлайн Жүгдэр. Өвөрхангай аймгийн зүүн Өлзийт сумын харьяат, 24 настай, 1941.07.15-ны өдөр цэрэгт ирсэн,

4.Түр цэрэг Ламжавын Ням. Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын харьяат, 29 настай, 1945.07.15-ны өдөр цэрэгт ирсэн,

5.Түр цэрэг Тувааны Самданжамц. Дорноговь аймгийн Иххэт сумын харьяат, 30 настай, 1945.07.15-ны өдөр цэрэгт ирсэн,

6.Түр цэрэг Цэрэннадмидын Маамуу. Дорноговь аймгийн Дэлгэрэх сумын харьяат, 1945.07.15-ны өдөр цэрэгт ирсэн,

7.Хөнгөн пулемётын наводчик Лувсанцэрэнгийн Аюуш. Өвөрхангай аймгийн Төгрөг сумын харьяат, 23 настай, 1942.08.15-ны цэрэгт ирсэн,

8.Доогийн Дагва. Хөвсгөл аймгийн Их-Уул сумын харьяат, 24 настай, 1943.08.15-ны өдөр цэрэгт ирсэн,

9.Гонийн Лхамрагчаа. Увс аймгийн Туруун (өнөөгийн Баруунтуруун) сумын харьяат, 1944.08.15-ны өдөр цэрэгт иржээ.

Жанчхүүгийн давааны байлдаанд амь үрэгдсэн дайчдыг мөнхүү газарт нь хүндэтгэлтэйгээр оршуулан дурсгалын хөшөөг нь босгосон бөгөөд хожим уг хөшөөг шинэчлэн засварласан нь өнөөгийн Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Хэбэй мужийн Жан бэй сиян (хуучнаар Бор хот)-ы нутагт байна.

“АЛТАН ГАР”-ТАЙ ЦЭРГИЙН ЭМЧ БУЮУ ТАВ ШАРХАДСАН БААТАР ПУЛЕМЁТЧИН

Цэргийн Явдлын Яамны Хүн эмнэлгийн хэлтсээс Чөлөөлөх дайнд хэлтсийн дарга, хурандаа З.Дугар, Офицрийн сургуулийн хүн эмнэлгийн албаны дарга, хошууч Л.Шаравдорж, эх зохиогч, ахлах дэслэгч С.Шарав, амбулаторийн бага эмч, ахлах дэслэгч Ц.Санжаа, Төв эм складын дарга, ахмад Ө.Мөнх, Эм складын тоо бүртгэгч, дэслэгч З.Батсүх нар явжээ. Тэд хамгийн багадаа нэг сар цаашилбал 63 хоног байлдааны үүрэг гүйцэтгэжээ.

Мөн нэгтгэл, ангийн эмч, сувилагч нар байлдааны фронтод үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн бөгөөд тэдний нэг нь хурандаа Д.Нянтайсүрэнгийн командалсан хуягт бригадын буудлагын нэгдүгээр батальоны бага эмч Г.Ламчогдон юм. Тэрбээр Жанчхүүгийн давааны байлдааны үед шархдагсдыг галын шугамаас татан авч эмнэлгийн анхны тусламжийг үзүүлэн хээрийн эмнэлэгт хүргэх ажлыг удирджээ.

Бага эмч Г.Ламчогдон хүнд шархадсан наводчик Д.Данзанваанчигт анхны тусламжийг хэрхэн үзүүлсэн тухайгаа, “Данзанваанчигийн царай зөвхийрэн цайж, цус алдсан нь илэрхий байсан ба бүх хувцсыг нь зүсэж салгаад цус гарч байгаа газрыг олов. Түүний баруун гар, зүүн хөл, ууц нуруунд сум нэвтэрсэн, нэвтрээгүй 5 шарх байлаа. Цусыг нь тогтоож, шархыг нь цэвэрлэн боож, хугарсан ясанд нь чиг тавиад “Өвдөж байна уу?” гэсэнд Данзанваанчиг, “Гайгүй байна” гэж хэлэхэд би “Аргагүй л хатуу, зоримог эр юм” гэж бодоод өрөөвдөж билээ. Тэрээр тэсэхийн аргагүй хүнд шархадсан

боловч ганц ч удаа ёолоогүй нь олон нөхдөө шархдахад сэтгэл гонсойж явсан миний урмыг сэргээж, зоригийг чангалж билээ” хэмээн өгүүлжээ.

Ийнхүү алтан гартай эмч нарынхаа ачаар амьд үлдсэн хөнгөн пулемётын наводчик Д.Данзанваанчиг удалгүй БНМАУ-ын Баатар цолоор шагнуулж, улмаар цэргийн эмч болон Цэргийн госпитальд ажиллаж байв.

ЧӨЛӨӨЛӨГДСӨН НУТГААР 20 ГАРУЙ ХОНОГ

Чөлөөлөх дайнд Монгол ардын хувьсгалт цэргийн Улс төрийн газраас 20 хүн мөн анги, нэгтгэлийн олон арван улс төрийн ажилтнууд оролцожээ. Зөвхөн Монгол ардын хувьсгалт цэргийн 6 дугаар морьт дивизэд улс төрийн ажилтан 33, намын гишүүн 571, эвлэлийн гишүүн 453, намын үүр 37, эвлэлийн үүр 19, ухуулагч 81, байлдааны хуудасны эрхлэгч 23 ажиллаж байв.

Тэд дайны фронтод зохиох нам, улс төрийн ажлаас гадна олон талын үүрэг гүйцэтгэж байсныг түүхэн баримтад тэмдэглэн үлдээжээ. Тэдний гүйцэтгэсэн нэг үүрэг нь чөлөөлөгдсөн нутгийн ард түмний дунд явуулсан ухуулга сурталчилгааны ажил байв. Тухайлбал, 5 дугаар морьт дивизийн 14 дүгээр морьт хорооны сумангийн улс төрийн орлогч Балдангийн Дэмчиг Өвөр Монголын Шилийн голын чуулганы баруун, зүүн Хуучид, баруун, зүүн Үзэмчин болон Авга засгийн буриад хошуудаар 20 гаруй хоног явж, БНМАУ-ын Засгийн газрын бодлого, хууль зүй, чөлөөлөх дайны зорилт, Монгол-Зөвлөлтийн арми Өвөр Монголыг чөлөөлсний ач холбогдлын талаар 10000 гаруй хүнд яриа хийжээ. Халхын голын болон Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин Б.Дэмчиг энэ тухайгаа хожим нь дурсан, “Энэ үеэр Өвөр Монголын ард түмэн манай армийн ар тал, уналга хөсгийн хангалтад зориулан 4 хошуунаас 3000 шилдэг сайн агт морио нийлүүлсэн. Би энэ ажлыг гүйцэтгэхдээ Шилийн голын чуулган яаманд очиж чуулганы дарга Сунчинваанчиг, түүний туслах Балгансүрэн нарт зар бичгээ үзүүлээд тэр яамнаас томилсон Аюуш залан, Цэрэн тахар нар болон газарчин, тууварчин авч хошуудаас тусалсан агтыг 5, 6, 8 дугаар дивизэд нийлүүлэх тушаалыг биелүүлсэн” хэмээн бичжээ.

“МОНГОЛ АРД УЛС ТҮЙЛДАА ХҮРТЭЛ МАНДУГАЙ!”

Монгол ардын хувьсгалт цэргийн анги, нэгтгэлүүдийн буцах марш 1945 оны 9 дүгээр сарын 15-ны өдрөөс эхэлж, Долоннуурт хүч хуралдуулан түр амралт хийжээ. Энэ үед 9 дүгээр сарын 24-ний өдөр Цэргийн дуу, танцны ансамблийн уран бүтээлчид анхны тоглолтоо хийв. Энэ нь тэмцэл, тулалдааны хүнд бэрх замд алжааж ядарсан байлдагч, түрүүч, офицеруудыг маш их баярлуулж, урам зоригийг нь сэргээсэн ажээ. Тоглолтыг дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн, хошууч генерал Д.Дамдинхүү, Дотоод явдлын яамны сайд Б.Шагдаржав нар дарга, цэргүүдтэйгээ зэрэгцэн сууж үзсэн бөгөөд тоглолтын төгсгөлд нийтээрээ “Манай хайрт удирдагч маршал

Чойбалсан мандтугай!”, “Монгол ард улс туйлдаа хүртэл мандтугай!” гэх зэргээр уриалж, “Манай эх орон” хэмээх дууг дуулан концерт “маш хөгжилтэй” болсон хэмээн түүхэнд тэмдэглэжээ. Үүний дараа Цэргийн дуу, танцны ансамблийн уран бүтээлчид Монгол ардын хувьсгалт цэргийн анги, салбар болон Өвөр Монголын ард түмэнд хэд хэдэн удаа тоглолтоо сонирхуулжээ.

Чөлөөлөх дайнаас хойш 10 жилийн дараа буюу 1955 оны зун Цэргийн дуу, бүжгийн ансамблийн уран бүтээлчид Бүгд Найрамдах Хятад Ард Улсад очиж, Хятадын ард түмэн, армийн дайчдад тоглолтоо үзүүлжээ.

Монгол ардын цэргийн Дуу, бүжгийн ансамбль Бээжин хотод 1955 оны 7 дугаар сарын 6-16-ны өдрүүдэд 7 удаа тоглоход 20500 хүн үзэж сонирхсон бөгөөд дараа нь Шанхай, Ханжоу хотынхонд тоглолтоо сонирхуулав. Үүнд БНХАУ-ын төр, цэргийн удирдагчид болон цэрэг дайчид, олон нийт ихээхэн талархаж, Чөлөөлөх дайны үед Жэхэ мужийн цэргийн тойргийн командлагчаар ажиллаж, МАХЦ-тэй холбоо тогтоож байсан Хятадын Агаарын цэргийн хүчний генерал Дуан Сучуан “Жень минь жибао” сонинд “МАЦ-ийн ансамблийг баярлан угтана” хэмээх өгүүлэл нийтлүүлэн БНХАУ-ын Ерөнхий сайд Жоу Эньлай ансамблийн уран бүтээлчдийг хүлээн авч, хүндэтгэн дайлжээ.

ТАНКАН ДЭЭР СУУН ЖЭХЭ ОРЖ ЯВАХДАА

Нэрт кино найруулагч Монгол Улсын Төрийн шагналт, Ардын жүжигчин Д.Жигжид, нэрт зураглаач Б.Дэмбэрэл нар Чөлөөлөх дайны фронтод ажиллаж, дайн, тулалдааны хүнд бэрх мөч, түүхэн агшныг кино зургийн хальснаа мөнхлөн үлдээжээ. Энэ тухайгаа найруулагч Д.Жигжид хожим нь, “Би кино аппаратаа бариад зохиолч Ойдовтой хамт танкны дээр суун Жэхэ орж явахдаа бид хоёр уран бүтээлээ ярьж хуучилдаг байлаа” хэмээн дурсан ярьдаг байжээ. Ийнхүү Чөлөөлөх дайны фронтоос зөвхөн дайны баатрууд төдийгүй ХХ зууны Монголын урлагийн нэртэй зүтгэлтнүүд, нэртэй уран бүтээлүүд төрөн гарсан ажээ. Зураглаач Б.Дэмбэрэл өмнө нь Халхын голын дайны фронтод кино зураг авч байсан туршлагатай уран бүтээлч байв.

“НАМАЙГ ГОЛООС ГАРГАХ ГЭЖ БАЙЖ МОРЬ МИНЬ ЭНДЛЭЭ”

Чөлөөлөх дайны түүхийг бичихдээ монгол морьдын тухай дурсахгүй өнгөрч үл болно. Учир нь морьт цэргүүд ямагт давшилын тэргүүн эгнээнд явж, техникийн анги, салбаруудын хүчин мөхөсдөж байсан эзрэм тал, элсэн манхан, өндөр уул, өргөн голыг хамгийн түрүүнд туулж, байлдааны үүргийг хамгийн шуурхай гүйцэтгэж байсан нь монгол морьдын шандас шөрмөсний хүч буюу.

Чөлөөлөх дайнд оролцсон Монгол ардын хувьсгалт цэрэг, Хилийн цэрэг, Сайн дурын морьт отрядын хэмжээнд хорь гаруй мянган хүлэг морьд явжээ. Зөвхөн 6 дугаар морьт дивизэд 9 дүгээр сарын 1-ний өдрийн байдлаар жагсаалын 3994, их бууны 442, хөсгийн 789, бүгд 5225 агт, 480 тэмээ,

272 шар байв. Үүний дээр Өвөр Монголоос цэргийн агтад нийлүүлсэн морьдыг нэмэх аваас Чөлөөлөх дайнд оролцсон монгол морьдын тоо доод тал нь 25000 орчим болох юм. Мөн дайнд оролцсон Зөвлөлтийн армийн морьт ангиудад манай улсаас агт уналга нийлүүлсэн байж болох юм.

Цаг хугацаатай өрсөн ширүүн давшилтын үед унаж явсан хүлэг мориноосоо салах нь монгол цэргийн хамгийн хүнд зовлон байв.

Монгол ардын хувьсгалт цэргийн 5 дугаар морьт дивиз Гүбэйкоу хотын өмнүүр урсдаг Чаоху голыг гатлахад дивизийн дарга генерал Ч.Доржпалам морьт цэргүүдийг 12 эгнээ болгож, аль чадал тэнхээ сайтай морьдыг урсгал талд нь гарган явуулжээ. Морьт сумангууд гол гаталж дуусах үед байлдагч Жагдалын морь эрэг дээр гармагц сөхрөн унаж, амьсгал хураав. Хамаг хүчээ шавхан эзнээ голын эрэг дээр гаргаад амьсгал хураасан хүлэг морио байлдагч Жагдал ихэд өрөвдөн, “Намайг голоос гаргах гэж байж морь минь эндлээ. Дөрвөн жил миний байлдааны хань минь болж ирсэн юм сан ... Би мориндоо өөрийнхөө талх, “сахар”-аас ч өгдөг юм” гэх зэргээр уйлан хайлах зуур эмээл, хазарыг нь авч, толгойг нь эх нутгийг нь зүг харуулаад, сүүлнээс нь туг үс авсан ба эмээлээ үүрэн эргэн эргэн харсаар цааш явж байсан нь үнэхээр өрөвдөлтэй байсан тухай ахмад дайчдын дуртгалд бичсэн байдаг.

ЯЛАЛТЫН БАЯРЫН АМЬСГАЛ ТЭНГЭР, ГАЗАРТ БАГТАХҮЙ

Ялалт байгуулсан Монгол ардын хувьсгалт цэргийн анги, нэгтгэлүүд 1945 оны 10 дугаар сарын дундуур байнгын байрлалдаа буцан ирэхэд дарга, цэргүүдийн ар гэр, ах дүүс болон орон нутгийн нам, төрийн байгууллага, ард иргэд нэн баяртай угтан авав. Тухайлбал, 5 дугаар морьт дивизийг 10 дугаар сарын 13-ны өдрийн 11.00 цагт Чойбалсан (өнөөгийн Дорнод) аймгийн Жаргалант сум (өнөөгийн Чойбалсан)-ын захиргааны бүх албан хаагчид, ажилчид туг далбаа барин жагсаж нэн баяр хөөртэй угтжээ. Энэ тухай эх сурвалжид, “Зарим хүмүүс лоозон тавьж байхад дивизийн хөгжим сайхан дуугаар эгшиглэн цувааны тэргүүнээс гарч жагсаалыг угтан байсан ард түмэнтэй үлдэв” хэмээн тэмдэглэжээ. Дивиз мөн өдөр түр амралт хийгээд 10 дугаар сарын 14-ний өглөө 05.00 цагт Хан уулын урд талаас Чойбалсан хот хүртэл 22 километр марш үйлдэж, Чойбалсан хотод цуваагаар орж ирэхэд хотын албан байгууллага ба ард түмэн жагсан угтаж, баяр хүргэн уриа лоозон тавьж, хүндэтгэн хүлээн авч байжээ.

Монгол ардын хувьсгалт цэргийн 7 дугаар морьт дивиз 1945 оны 10 дугаар сарын 7-ны өдөр эх орныхоо хилийг давж, 10 дугаар сарын 10-ны өдөр Сүхбаатар аймгийн Хонгорыг чиглэн явж байхад Онгон, Дарьганга сумын хөдөлмөрчид туг далбаа барин жагсаж, ялалтын баяр хүргэн угтжээ. Дивиз маршаа үргэлжлүүлэн 10 дугаар сарын 11-ний өдрийн 11.00 цагт Байшинтад хүрэлцэн ирэхэд цэргийн алба хаагчид, дарга нарын гэр бүл болон ардууд баяр хөөртэй угтан авч баярын цуглаан хийжээ.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД


ЦЭРГИЙН АНСАМБЛИЙН ХУНДАГАА

Хөрөг дурсамж

Сайхан дуулдаг хүүхэнтэй
Сайн драпан шинельтэй
Хурандаа шахам цолтой
Хороо шахам цэрэгтэй
Цэргийн клубийн Хундагаа
дарга
Цэмцэгэр ганган эр дээ гэж
түүнийг нөхөд нь хошигнодог
байлаа.

Офицеруудын ордонд хүндэтгэлтэйгээр залагдсан зурагнууд дунд "Ансамбль"-аар овоглосон цэл залуу офицер эрийн зураг нүдэнд тусна. Энэ хүнийг М.Хундагаа дарга гэх бөгөөд цаанаа л нэг увдислаг, хүмүүсийн анхаарлыг гойд татдаг байсан тухай түүнтэй нөхөрлөж явсан хүмүүсийн ярианаас мэдрэгдэнэ. Ахмад дайчин, бүжигчин Х.Ёндоны санаачилгаар 1986 онд "Дайчин алдар" чуулгын анхны концертыг зохион байгуулахад би найруулагчаар нь томилогдож Чөлөөлөх дайнд оролцсон олон арван ахмадуудтай уулзан тэдний баатарлаг үйлс, фронтын тоглолтын талаар чих дэлсэж байсан юм. Намайг "Хундагаа дарга гэж ямар хүн байсан бэ?" гэж асуухад "Чөлөөлөх дайнд Цэргийн ансамблийг удирдан явсан гал цогтой, өндөр шаардлагатай, гялалзсан хүн байсан. Спортод их сайн, сонс эргэдэг мөн цэвэр цэмцгэр, залуу хүн гэхэд эрт ухаажсан, хэрсүү хүн байж билээ" хэмээн ахмадууд ярьж байсан нь санаанд үлджээ.

Дараа нь Хундагаагийн Саранчимэг гэж аавынхаа адил насаараа урлаг, соёлын байгууллагад ажилласан, өдгөө тэтгэвэрт суугаа эмэгтэйтэй ярилцсан юм. Тэр бээр "Аав минь байсан бол 100 гаруй наслах байжээ. Намтраас нь харвал, 1916 онд Увс аймгийн Давст сумын нутагт Моголцогийн ууган хүү болон төржээ. Багаасаа бичиг, эрдэмд шамдан суралцаж, 1931 онд сумын захиргаанд бичээч, нарийн бичгийн дарга, 1934 онд Аймгийн шүүхэд бичээчээр ажиллаж байгаад 1936 онд Ардын цэргийн албанд татагдан улмаар Цэргийн ерөнхий сургуулийг төгссөн. Сургуулиа төгсөөд Цэргийн яамны эвлэлийн товчоо, 7 дугаар дивизийн эвлэлийн товчоонд даргаар ажиллаж байгаад 1943 онд улс төрийн удирдагч цолтойгоор Цэргийн төв клубийн даргаар томилогдсон. Цэргийн клубийн даргаар ажиллаж байхдаа дайнд явсан юм. Ээжийг минь Гомбын Лхам гэдэг, Булган аймгийн хүн. Мөн л цэргийн ансамбльд дуучин байсан. Уг нь Улаанбаатар хотноо Арьс, ширний үйлдвэрт ажиллаж байхдаа сайн дурын уран сайханчдын концертод оролцсоноор Цэргийн Ансамбльд дуучнаар орох зам нь нээгдсэн. Ингээд автай танилцаж гэр бүл болсон" хэмээн хуучилсан. Түүний ээж дуучин Г.Лхам богино хугацаанд дуулах авьяас, чадвараа сайжруулан тухайн цагтаа алдартай дуучин байжээ. Би аавынхаа дэргэд 27 нас хүртлээ цуг байсан ба нэг удаа аав "одоо чи амьдралаа бод" гэснээр нөхөртэйгөө гэрлэсэн аж. Тэр



бээр "Ээж минь 1949 онд машины ослоор цэл залуугаараа хорвоог орхиж аав маань өнчин хэдэн охидоо өсгөсөн дөө. Аавыг минь Ю.Цэдэнбал дарга дуудуулсан гэхээр нь яваад очтол дарга "Эхнэр чинь харамсалтайгаар нас барлаа, та цэргийн хүн хатуужилтай, тэвчээртэй байдаг юм шүү. Хүүхдүүдийг чинь бид харж халамжилна" гэж хэлсэн тухай хожим нь бидэнд ярьж билээ. Тухайн үед генерал С.Батаагаар ахлуулсан комисс томилогдож ээжийг минь Улиастайд цэргийн хүний ёсоор нутаглуулсан. Хожим нь бид тэр газрыг олж дурсгалын чулуу босгосон. Аав минь хүнийг их хайрлана, хааяа жаахан юм балгачихаад "Гандий мод"-ыг аялж гунигтайхан сууж байдаг дүр нь сэтгэлд үлджээ. Нэг удаа зориглон "Та аяга цай хувааж уух ханьтай болбол яасан юм бэ" гэвэл над руу сүрхий харснаа "Ээжийг чинь гүйцэх хүн олдсонгүй ээ" гэж нулимстай, гунигтайхан харцаар харж билээ. Аав минь эрт босно, босоод бидний гутлыг гялалзтал тослоод тавьчихна. Өөрөө ч их цэмцгэр, халимгаа хагалж самнаад, гутлаа тослоод гарч өгнө. "Элдэв-Очир" кино театрын дарга байхад нь манайх гэдэг айл кино механикчийн өрөөний дэргэдэх жижигхэн өрөөнд амьдардаг байлаа. Хэдийгээр зуруухан байсан ч эцэг маань огт тоодогүй, ажлын төлөө л зүтгэдэг байв. Аав биеийн байдлаасаа болж 1951 онд цэргээс халагдах үед нам, засгийн удирдлагаас анхаарч Зөвлөлт Холбоот Улс руу явуулан бөөрний хагалгаанд оруулсан нь түүний гавьяа, зүтгэлийг үнэлж байсны илрэл биз. Соёлын яамны орлогч сайд Ч.Лодойдамба Төмөр замын соёлын ордныг байгуулж даргаар нь аавыг минь томилж ажиллуулсан. Мөн Соёлын яамны сайд эргүүлж "Элдэв-

Очир" кино театрын даргаар дахин томилоход Шар дэлгүүрийн урд талд баригдсан шинэ байрнаас хоёр өрөөг өгснөөр бидний амьдрал сайжирсан. Тэр байранд алдартнууд байхын зэрэгцээ манайхаар урлагийн томчуул их ирнэ. Тухайлбал, зохиолч Л.Ванган, Ч.Ойдов, гавьяат жүжигчин Цэрэндулам, гавьяат эмч Л.Шаравдорж, түүхийн ухааны доктор Г.Цэрэндорж, жүжигчин Л.Дуламжав зэрэг хүмүүс байнга л ирж, очдог байлаа. Намайг хөгжим бүжгийн дунд сургуульд ороход аав маань баярлаж "нэг нь ч гэсэн урлагийн хүн боллоо" гэж билээ.

Ээжийг "Цэнхэр дурдан алчуур" буюу "Амрагийн дуу"-г анхлан дуулагч Г.Лхам гэдэг байсан. Нэрт зохиолч С.Удвал "Үнэн" сонин 1947 оны 163 дугаарт "Урлагийнхаа их амжилтыг сэтгэл бахдан үзэв" сурвалжилгадаа "Бүх цэргийн төв клубийн наадмын талбайд концерт сонирхсон наадамчид В.Гомбо, Х.Ёндон, Лувсандорж нарын тоглосон морин цэрэг бүжиг, уртын дуучин В.Пунцаг, дуучин Г.Лхам нарыг дуулахад тун их магтав" гэж бичсэн. Гавьяат жүжигчин, дуучин Б.Төмөр 1947 онд Цэргийн ансамбльд ороод ээжийн минь шавь, дагалдан дуучин болсон. Тэр бээр ээжийн минь талаар "Багш маань надад "Амрагийн дуу"-г зааж өгсөн. Би энэ дууг 40 гаруй жил дуулж байна. Багш маань жинхэнэ монгол эмэгтэй байсан" гэж дурсан ярьсан нь үлджээ.

Аав минь 1951 оноос Улсын төв театр, "Элдэв-Очир" кино театр, Төмөр замын соёлын ордон, "Ард" кино театрын зохион байгуулах албаны дарга болон даргаар 30 гаруй жил ажиллаж Нийслэлийн соёлын байгууллагуудыг хөгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг насан эцэс болтлоо оруулсаар байсан юм.

Аавтай минь хамт 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдаас манай улсын урлаг, соёл, шинжлэх ухааны зүтгэлтнүүд төрөн гарч энх цагийн бүтээн байгуулалт, эх орныхоо соёлын бодлогыг хэрэгжүүлэхэд үнэтэй хувь нэмэр оруулжээ. Тэднээс ардын жүжигчин Б.Сэвжид, гавьяат жүжигчид Ё.Цэрэндулам, Ва.Гомбо, Д.Цэрмаа, М.Дорж, Г.Дамбийжанцан, уртын дуучин Ва.Пунцаг, нэрт жүжигчин В.Александр, "Дайчин алдар" чуулгын дарга, дипломатч Х.Ёндон, түүхийн ухааны доктор

Г.Цэрэндорж, театрын нэрт зүтгэлтэн Ц.Раднаа, кино жүжигчин Дуламжав нарын олон алдартнууд төрөн гарчээ. Тэд маань өнөөдөр бидний дунд нэгэнт үгүй болжээ. Түүх алдартнуудыг төрүүлж цаг хугацааг шалгадаг гэдэг. Өнөө цагт гавьяатан олширсон цаг дор жинхэнэ гавьяатан олоход төвөгтэй ч болсон юм шиг.

Цэргийн дуу, танцны ансамбль Чөлөөлөх дайнд оролцсон номын хуудсыг сөхвөл, ахмад дайчин Х.Ёндон, цэргийн яруу найрагч Лувсан гуайн дурсамжид "1945 онд Цэргийн явдлын яамны сайдын тушаалаар МАХЦ-ийн Дуу, танцны ансамбль 60 хүний бүрэлдэхүүнтэй байлдааны үүрэг гүйцэтгэхээр фронтын зүг мордсон" тухай сонирхолтой дурсамжууд бий. Тухайлбал, 1945 оны Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчин П.Лувсангийн дурсамжид "Намрын сар гараад цэргийн клубийн

үйлчлэн эх орныхоо хөгжил, цэрэг армийнхаа баатарлаг гавьяаг сурталчлах, цэрэг дайчдыг ая дуугаараа зоригжуулан ялалтад уриалан концертоо тоглоно. Байлдааны даалгаврыг нэр төртэй биелүүлэхийг та нартаа уриалж байна" гэсэн залуу даргын дуу хоолой домог болон үлджээ. Гавьяат жүжигчин Ё.Цэрэндулам дурсамждаа "Тэнгэр-элс гэж зах нь харагдахгүй цөлд машинуудаа элсэнд суулгаад татаж гаргах гэж хамаг тамираа барна. Дээр нь дайснууд ухрахдаа худгийн усыг хордуулсан тул өлсөж, цангах энүүхэнд байв. Монгол хүн давсалсан загасаар яаж хоолших вэ?, зарим үед өдөрт 4-5 удаа концертоо тоглоно, бид залуу тулдаа л давж гарсан даа. Байлдаанд оролцоогүй ч гэсэн дайны хүнд бэрхийг туулж, сэтгэл эмзэглэн аймшигт нөхцөл алхам бүрд минь тохиолдож байжээ" хэмээн өгүүлсэн байна.



түлээний хашаанд хоргодох байрны харилцах шуудууг ухаж байтал жижүүрийн зарлага Лувсанбалдан ирж "Машины ирлээ" гэв. Бид "хашхирагдан" газар ухаж байсан хүрээ хаяцгаан цэргийн клуб дээрээ ирэхэд "Шевролет" загварын машинууд байв. Клубээр дүүрэн хөл үймээн эмэгтэйчүүд нь нагаан буу бүсэндээ зүүчихсэн, эрэгтэйчүүд нь винтов барьчихсан сумны хонгио зөөж оруулна. Маргааш нь гурван "Шевролет" машинд жүжигчид сууж, бидний хэдэн цэрэг "ЗИС-5" машинтай замд гарч билээ. Дайнд мордохын өмнө М.Хундагаа дарга Ансамблийн бие бүрэлдэхүүний бэлтгэлийг нь шалгаж дуусаад "Та бүхэн эх орныхоо тусгаар тогтнолын төлөө дайны талбар руу нэг гартаа буу, нөгөө гартаа хөгжмөө барьж цэрэг эрсийн адил эх орныхоо өмнө хүлээсэн үүргийг нэр төртэй биелүүлэх боллоо. Ах, дүү Монгол-Зөвлөлтийн армийн дайчид, чөлөөлөгдсөн орны ард түмэнд урлаг, соёлоор

Энэ дашрамд өгүүлэхэд ЦДБЭЧ-ын дарга, хурандаа Б.Золзаяа болон хамт олон нь санаачлан 2020 оны эхнээс ахмад дайчдын гавьяа, зүтгэлийг нь алдаршуулах, мөнхжүүлэх зорилгоор хүндэтгэлийн буланг байгуулах, дайны үед тоглож байсан уран бүтээлийг нь сэргээж тоглох, хөгжимт драмын жүжгийг тавих бэлтгэлээ хангажээ.

Мөн Өвөр Монголын өөртөө засах орны Авга хошууны Телевиз хороотой хамтран "Ялалтын дууль" баримтат киног бүтээхээр ажилдаа ороод байна. Харин өнөөгийн цар тахлын улмаас БНХАУ-д зургаар авах ажил түр хойшлогдоод байгаа юм.

Цэргийн ансамблийн дарга М.Хундагаагийн цэл залуугаараа бидний сэтгэлд үлдсэн түүх ийм буюу. Алдартан хэдий үгүй боловч ажил үйлс нь мөнх байх ажгуу.

Цэргийн дуу бүжгийн Эрдмийн чуулгын найруулагч асан чөлөөнд байгаа хошууч С.БОЛД

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙН-ОНЦЛОХ 10 БАРИМТ

Чухам яагаад 1945 оны 8 дугаар сарын 9-ний өдрийг товловсон бэ?

1945 оны хоёрдугаар сард Ялтад зохион байгуулсан Бага хурал дээр И.В.Сталин Зөвлөлт Холбоот Улс дайнд ялалт байгуулсныхаа дараа гурван сарын дотор багтаж Японы эсрэг дайн зарлана гэж мэдэгдсэн түүхтэй. Энэ ч ёсоор Зөвлөлт Холбоот Улс фашист Германыг ялсан түүхэн ялалтаас хойш удалгүй 8 дугаар сарын 8-ны өдөр дайн зарласны маргааш нь буюу 9-ний өдөр хил нэвтрэн орсон байдаг.

XX зууны Монголын түүхэн дэх хамгийн их цэрэг оролцсон дайн

Монгол ардын хувьсгалт цэрэг Өвөр Байгалийн фронтын бүрэлдэхүүнд Монгол-Зөвлөлтийн морьт механикжуулсан бүлэгт багтаж байв. Тус бүлгийг "Өмнөд бүлэг" ч гэж нэрлэдэг. Өмнөд бүлэгт 43,000 орчим цэрэг байсны 21,384 мянган цэргийн алба хаагч нь Монгол цэрэг байв. Энэ бол XX зууны түүхэн дэх Монголын хамгийн их цэрэг оролцсон үзүүлэлт болсон юм.

Харин Японд хэн дэмжлэг үзүүлж байв?

Квантуны армийн бүрэлдэхүүнд тухайн үед тоглоомын улс болсон Манж Го-ийн 170-200 мянган хүнтэй арми болон Дэ вангийн Мэнзьяны 44 мянган хүнтэй арми багтаж байв. Өвөр Монголын нутаг дэвсгэрт үзсэн байгуулагдсан Мэнзьян хэмээх тоглоомын улсын армийг сонирхолтой нь Японы тусламжтайгаар Хятадаас тусгаар тогтнох зорилго өвөрлөсөн Чингисийн удмын ноён Дэмчигдонров толгойлж байсан билээ. Мөн цөөн тооны Солонгос цэргүүд болон хаант Оросын үед дүрвэн гарсан цагаантны цэргүүд байжээ.

Хоёр талын хүчний харьцаа

Монгол-Зөвлөлтийн гурван фронтын цэрэг 1,7 сая хүнтэй, үүнээс 21,384 цэргийн алба хаагч нь манай улсынх байсан ба тус фронт нь 26 мянга орчим их буу, 1852 өөрөө явагч их буу, 5556 танк, 5368 нисэх онгоцтой байв. Харин Японы Квантуны арми 993 мянга орчим цэрэг, Манжийн тал 200 мянга орчим, Дэ вангийн цэрэг 44 мянга буюу нийт 1 сая

200 мянга орчим цэрэгтэй, 1215 танк, 6640 их буу, миномёт, 1907 нисэх онгоц, байлдааны 26 хөлөг онгоцтой байлаа.

Япончууд Зөвлөлт-Монголын цэрэгт хоёр дахь удаагаа ялагдсан

Японы Квантуны арми өмнө нь 1939 оны Халхын голын дайнд Монгол-Зөвлөлтийн цэрэгт бүслэгдэн бут цохигдон томоохон ялагдал хүлээн дайны стратегиа тэнгис, далай тийш шилжүүлсэн. Харин Чөлөөлөх дайнд дахин ялагдаж бүр мөсөн сүйрсэн юм. Харин Зөвлөлтийн цэрэгт Хасан нуур, Халхын гол, Чөлөөлөх дайнаар дахин ялагджээ.

Дайны үндсэн зорилго юу байв?

Зөвлөлт Холбоот Улсын зорилго нь 1905 оны Орос-Японы дайнаар алдсан өмнөд Сахалин, Куриллийн арлуудыг эргүүлэн авах болон Ялтын бага хурлаар хүлээсэн үүргээ биелүүлэх байсан бол Бүгд Найрамдах Монгол Ард Улсын зорилго нь Өвөр Монгол болон бусад монгол овогтноо нэгтгэх улмаар зүүн хойд Хятадыг чөлөөлөн тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх явдал байжээ.

Монгол цэрэг Хятадын цагаан хэрэмд сүүлчийн удаа хүрсэн

Монгол ардын хувьсгалт цэрэг Чөлөөлөх дайнд оролцон Хятадын их цагаан хэрэм хүртэл давшсан нь 1915 оны Таван замын байлдаанаас хойших хоёр дахь тохиолдол байв. Энэ нь XX зуун гарснаас хойш Монгол цэрэг Хятадын Цагаан хэрэмд хүрсэн хоёр дахь бөгөөд сүүлчийн тохиолдол болжээ.

Чөлөөлөх дайны баатрууд

Чөлөөлөх дайны үед Монгол ардын хувьсгалт цэргийн ангиудын хувьд томоохон байлдаан нь Жанчхүүгийн даваанд болсон бөгөөд энд 7 дугаар хуягт бригадаас 13 хүн амь үрэгдэж, 21 хүн шархадсан юм. Мөн энэ байлдаанд оролцогчдоос Л.Аюуш, С.Дампил, Д.Данзанвананчиг, М.Жанчив, Т.Дүүдэй нар БНМАУ-ын Баатар цол хүртсэн юм.

БНМАУ-ын төр, засаг дайны дараа Чөлөөлөх дайнд оролцож байлдааны ажиллагааг чадамгай удирдан, гарамгай байлдсан Монгол ардын хувьсгалт цэргийн генерал, офицер, түрүүч, байлдагч 2300 гаруй хүнийг

төрийн одон, медалиар шагнаж урамшуулснаас 500 орчим нь Байлдааны гавьяаны улаан тугийн одонгоор шагнуулжээ. Мөн Зөвлөлт Социалист Бүгд Найрамдах Холбоот Улсын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн зарлигаар Монгол ардын хувьсгалт цэргийн 302 генерал, офицерыг одон, медалиар шагнасан ажээ.

Зөвлөлтийн улаан армийн 513 генерал, офицер, бага дарга, цэргийг Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төрийн одон, медалиар шагнасан байна.

Анх удаагаа Өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд оролцсон

Монгол Улсаас анх удаагаа энгийн ард иргэдээс бүрдсэн Ардын өөрийгөө хамгаалах сайн дурын морьт отряд хоёр чиглэлээр Чөлөөлөх дайнд оролцсон. Энэхүү отрядад 1100 орчим хүн байсан ба дайсны хорлон сүйтгэгчидтэй тэмцэж, байлдаан болж өнгөрсөн газар оронд дэг журам тогтоох, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын төр, засгийн бодлогыг сурталчлахад туслалцаа үзүүлэх үүргийг гүйцэтгэжээ.

БНМАУ-ын хүн хүчний хохирол

1945 оны Чөлөөлөх дайнд Монгол ардын хувьсгалт цэргийн хохирлыг өнөө болтол нэг мөр болгон эцэслэн тогтоож гаргаагүй бөгөөд тэдгээр тоо баримтууд хоорондоо ихэд зөрүүтэй байдаг юм. МАХЦ-ийн 93, 122, 179, 524 хүн байлдаанд амь үрэгдэж, шархадсан, сураггүй алга болсон, өвчнөөр болон бусад ослоор нас барсан гэх зэргээр зөрүүтэй бичдэг. 1946 онд маршал Х.Чойбалсанд танилцуулсан илтгэлд Чөлөөлөх дайнаар нийтдээ 124 хүн, эд материалын талаар 195 сая төгрөгийн хохирлыг Бүгд Найрамдах Монгол Ард Улс хүлээсэн гэж тооцоолсон байна.

Монгол ардын хувьсгалт цэргийн Улс төрийн газрын дарга, дэслэгч генерал Ю.Цэдэнбал хүн хүчний хохирлыг байлдаанд нас барсан-10, гэнэтийн аюулаар нас барсан-16, өвчнөөр нас барсан-10, усанд амь үрэгдсэн-8, шархадсан-36, ор сураггүй болсон-32, бүгд 122 хүн гэж гаргасан нь хамгийн бодитой тоо юм.

Доктор (Ph.D), хошууч Т.СҮХБААТАР



ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТЫН 75 ЖИЛИЙН ОЙД

“БИД ЯЛАВ” ҮЗЭСГЭЛЭНГИЙН ҮЗМЭРИЙН ДЭЭЖСЭЭС

Фашизмын эсрэг тэмцэлд Бүгд Найрамдах Монгол Ард Улс Зөвлөлтийн Улаан Армийн дайчдын хамт мөр зэрэгцэн тулалдаж олон арван мянган цэрэг эрсийн халуун амь, бүлээн цусаар ялалтыг авчирсныг түүх мартаггүй. Монгол цэргийн музейгээс Чөлөөлөх дайны ялалтын 75 жилийн ойд зориулан “Бид ялав” сэдэвт үзэсгэлэнг өөрийн музей, Батлан хамгаалах яамны архив, Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй БНМАУ-ын баатрууд, дайнд оролцсон эрхэм дайчдын түүхэн үнэнийг гэрчлэх биет эд өлгийн зүйлс, түүхийн баримтад түшиглэн дэглээд байна.

“Бид ялав” үзэсгэлэнгээрээ Чөлөөлөх дайнд оролцсон Монгол ардын хувьсгалт цэргийн командлагч, маршал Х.Чойбалсан, жанжны орлогч бөгөөд Улс төрийн газрын дарга, дэслэгч генерал Ю.Цэдэнбал, жанжны орлогч, дэслэгч генерал Ж.Лхагвасүрэн, Улс төрийн газрын дарга, хошууч генерал С.Равдан, МАХЦ-ийн Арын албаныг удирдах газрын дарга, хошууч генерал Р.Осор, МАХЦ-ийн Их бууны газрын дарга, хошууч генерал Г.Рэндоо нарын үзэмэр, эд өлгөөс гадна монгол цэргийн эр зориг, тэсвэр хатуужлын гайхамшигийг үзүүлж, аагим халуун, элсэн цөл, үргэлжилсэн аадар бороо, Хянганы өндөр уулсыг үл ажран өмнөө тавигдсан байлдааны үүргээ амжилттай биелүүлж дайны талбарт амь биеэ үл хайрлан тэмцсэн, БНМАУ-ын баатрууд, эрэлхэг дайчдын эдлэх хэрэглэж байсан эд зүйлс, түүхэн баримтуудыг дэглэн үзүүлж, алдар гавьяаг нь таниулан сурталчилж, мөнхжүүлэхийг зорилго.

Энэхүү үзэсгэлэнд 8 дугаар морьт дивизийн холбооны суманд холбоочин, тагнуулчнаар үүрэг гүйцэтгэсэн Ц.Дамдинжавын дайны үед хэрэглэж байсан дашмаг, одон, медаль, баримт бичиг, Б.Цоодол, Дариймаа, Г.Дагва, Л.Батмөнх, Ж.Ядмаа, Н.Жамбал, Б.Дашцэрэн, Б.Банзрагч, Ц.Чимэддорж, Ж.Гончигжалцан, Б.Цэвээндорж, С.Отгонбаяр болон эдүгээ 99 настай ахмад дайчин Цэрэнхандын Даш нарын дайнд оролцсон үнэмлэх, баримт бичиг, гэрэл зураг, Батлан хамгаалахын төв архивын сан хөмрөгт хадгалагдаж буй анги, дивизүүдийн түүх, байлдаанд оролцогсод олгосон “Бид ялав” медалийн бүртгэл, байлдааны ажиллагааны зураг, Батлан хамгаалах яамны архиваас Чөлөөлөх дайнд оролцсон ахмад дайчдад үнэмлэх олгосон бүртгэлийг анх удаа толилуулж байна.

Тэрчлэн музейн сан хөмрөгт хадгалагдаж буй БНМАУ-ын баатар Д.Данзанваанчиг, С.Дампил, Л.Дандар, Н.Хаянхярваа, 8 дугаар дивизийн холбоочин Ц.Дамдинжав, сувилагч Г.Долгоржав болон 20 гаруй ахмад дайчдын үнэмлэх, баримт бичиг зэрэг 200 гаруй эд өлгийн зүйлийг тус үзэсгэлэнд дэглэн үзэгч олны хүртээл болгож байгаагаас уншигч та бүхэнд доорх үзэмрийг дэглэн хүргэе.

БНМАУ-ын 1945 оны 8 дугаар сарын 2-ны өдрийн 51 дүгээр тогтоолоор “Ардын хувьсгалт цэргийн жанжин туг”-ийг үйлдэх шийдвэр гарчээ.

БНМАУ-ын шинэ Үндсэн хуулийг баталсны дараа ийнхүү шинэчилсэн бөгөөд “БНМАУ-ын Ардын хувьсгалт цэргийн Жанжин туг” хэмээсэн худам монгол бичигтэй,



БНМАУ-ын Ардын хувьсгалт цэргийн жанжин туг 1945-2014 он

150x200 см-ийн хэмжээтэй, дундаа төрийн сүлдтэй, улаан хүрэн өнгийн хамба хилэнгээр хийсэн, гурван талдаа шар өнгийн торгомсог утсаар урласан цацагтай бөгөөд догны суурь, иш цацгийг мөн өнгийн утсаар урлан бүтээжээ.

Монгол цэргийн оройн дээд шүтээн нь Жанжин туг байсан агаад түүнийг 1945-1992 онд төр, засгийн тэргүүн нар зочлоход мөн улсын баяр наадмын цэргийн парадын үед цэргийн жагсаалын өмнө залдаг байжээ. Цагаан морин жилийн ардчилсан хувьсгалын үр дүнд Монголын төр, цэргийн түүхэн уламжлал, ард түмний үндсэн үзэл, уламжлалт зан үйл сэргэж Бүх цэргийн Их хар сүлдээ бүтээн залж, 1992 оны 5 дугаар сарын 5-ны өдөр БХЯ-нд гардуулж өгсөн байна. Түүнээс хойш уг Жанжин тугийг БХЯ-нд хадгалж байгаад БХЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2000 оны 9 дүгээр сарын 14-ний өдрийн 180 дугаар тушаалаар Зэвсэгт хүчний төв архивд шилжүүлжээ. Ийнхүү “Ардын хувьсгалт цэргийн Жанжин туг”-ийг тус архивд хадгалж байгаад 2003 онд ЗХЖШ-ын даргын тушаалаар Жанжин штабын нэгдүгээр давхар тусгай хоргонд залж байрлуулан, уг тугийг залах, арчлах журмыг баталсан бөгөөд 2012 онд энэхүү журмыг шинэчилжээ. 2013 онд ЗХЖШ-ын даргын тушаалаар томилогдсон комисс Жанжин туганд үзлэг хийж 70 орчим жил ашигласан, хадгалалтын явцад элэгдэл их үүссэн ч Монгол Улсын Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний сүсэглэн дээдлэх оройн дээд шүтээн, түүхийн дурсгалт үзэмр болох тул Зэвсэгт хүчний Жанжин тугийг шинээр бүтээж “Ардын хувьсгалт цэргийн Жанжин туг”-ийг ЗХЖШ-ын даргын 2014 оны тушаалаар Монгол цэргийн музейд шилжүүлэн өгсөн түүхтэй.

Д.Данзанваанчигийн дурдатгалаас сонирхуулахад, “Би миномётоо цоо шинэ байхад нь хүлээн авсан билээ. ЗХУ-д үйлдвэрлэгдсэн ёстой л тостой



“Цагаан хэрмийн дэргэд”. Уран бүтээлч Н.Чүлтэм. Зотон, тос, 136x150, 1997 он



МАХЦ-ийн арын албаныг удирдах газрын дарга, хошууч генерал Р.Осорын сэлэм 1944 он

гараар баримгүй, тоостой газар тавимгүй сайхан зэвсэг байсан бөгөөд цэрэг хүн төдийгүй ер нь эр хүн бүхний хайрыг аргагүй татаж чадах сайн буу байлаа. Тэгээд ч энэ буу миний амьдрал, хүмүүжилд төдийгүй манай Ардын Армийн дайчин замналд мартагдашгүй дурсгал болж үлдсэн. Миномётоо хүлээж аваад зөвхөн арьс ангийг нь арчиж зүлгэж ил харагдах эрэг шураг, оньс механизмыг



БНМАУ-ын баатар Дашийн Данзанваанчигийн 50 мм-ийн миномёт

нь үзэж сонирхохоос цааш мэдэх, чадах юмгүй байлаа. Миномёт салааны бага дэслэгч Санжаар бууныхаа арга ажиллагааг заалгаж эхлэв. Манай салааны дарга Санжаа Улаанбаатарт курс хийж, семинар сонссон, ялангуяа миномётыг сайн судалсан хүн байсан юм. Эхлээд бие анги, харилцан ажиллагаа, буудлагын онол гэх зэрэг хэдэн төрлийн сэдвийг шат дараалан заалгаж судаллаа. Дараах шат нь галын бэлтгэл сургууль байв. Энэ үед би туслах наводчик байсан учир өөрийн үүрэгт ажилдаа сайн суралцав гэж даргадаа үнэлэгдэж, оролдсоор байж жинхэнэ наводчийн зэрэгт хүрч чадсан. Өдий зэрэгтэй суралцахад манай нэгтгэлийн дарга, хурандаа Д.Нянтайсүрэн, сургагч нарын туслалцаа ихээхэн хувь нэмэр болсныг үргэлж санан дурсдаг. 1945 оны 6 дугаар сарын эцсээр манай бригадын орон тоонд өөрчлөлт гарч би жинхэнэ наводчикаар дэвшлээ. Бид байлдааны бүх ажиллагаагаар хэерийн сургууль хийж Замын-Үүд, цаашаа хил дээр хүрч, тэндээс ах дүү Өвөр Монголыг чөлөөлөх тушаалыг 8 дугаар сарын 9-ний өдөр авснаар 10-ны өдөр ариун шударга дайнд мордох хил давав. Миний миномёт бол дайсны галын цэгийг ил далд хамаагүй бууддаг, дагуу хөндлөн усан хэмжүүр бүхий 800-1000 метр зайд хараа тохируулан сууж бууддаг юм. Давшилт дундуур би дайсны 10 шахам цэгийг устгаж, Жанчүүгийн давааны ширүүн тулалдаанд хоёр бөөрөндөө шарх авсан ч даргадаа хэлэхгүй урагшлан тулалдаж байтал баруун гараа хуга буудуулан ар талын эмнэлэгт хүргэгдэн Баянтүмэнгийн эмнэлэгт сар болоход С.Дампил, Л.Аюуш бид гуравт БНМАУ-ын Баатар цол шагнасан тухай мэдээг сониноос олж уншсанаа нөхөд минь надад мэдэгдэв. Дайны төгсгөл хүртэл явж чадаагүйдээ гунихарсан ч энэ бүгд буудлагын хичээл заасан багш, шадар дарга нар, ижил дасал болсон



байлдагч нар болон миний миномётын минь ач гэж санагдан хязгааргүй их баярласан билээ” хэмээсэн нь бий.

Мөн БНМАУ-ын Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн, Дэлхийн олон улсын улаан загалмайн “Флоренс нигитингале” алтан медальт, ахмад дайчин, сувилагч Ж.Долгоржавын дайны үед хэрэглэж байсан багаж хэрэгслийг энэ удаа дэглэн үзүүлж байна.

Хурандаа Г.Нянтайсүрэн даргатай 7 дугаар механикуулсан хуягт бригадэд Гавьяат эмч, дэд хурандаа Даш, хурандаа Л.Шаравдорж, бага эмч Сундуй, Дампил, Самдан, их эмч Жанлав, Чимэддорж, сувилагч Дашцэрмаа, Дулам, жолооч Отгон нар болон Зөвлөлт, Монголын эмч нарын заавар, тушаалыг биелүүлж Цагаан нуур, Их Хянганы нуруу, Долоннуур, Жамбай хот, Чуулалт хаалга, Сөнөд цагаан овоо, Жээх хот зэрэг газруудын ард түмнийг Япончуудын дарлалаас чөлөөлөх энх тайван, эрх чөлөө, тусгаар тогтнолыг

олоход оролцож, шархадсан цэрэг дайчдыг сувилах, асрах, сэтгэл санаагаар дэмжих, хүнд шархдагддаг эмнэлгийн тусламжийг шуурхай, цаг алдалгүй



Ахмад дайчин сувилагч Ж.Долгоржавын эд зүйлс

үзүүлэхийн зэрэгцээ ар талд эмнэлэгт шилжүүлэн хүргэх хугацаанд хүнд шархадсан дайчдын амь насыг аврахын тулд цусаа хүртэл өгч байлаа. Үүний нэг жишээ нь БНМАУ-ын баатар Д.Данзанваанчиг 1979 он хүртэл бахархал дүүрэн амьдрахад нь дайны үед үзүүлсэн миний хувь нэмэр орсон гэж ихэд баярладаг тухайгаа ахмад дайчин сувилагч Ж.Долгоржав дурдатгалдаа тэмдэглэн үлдээжээ.



5 дугаар морьт дивизийн 13 дугаар морьт хорооны дарга, хурандаа Л.Дандарын цүнх

| | | | | | |
|--------------------|-------------------------------|--|--|--|--|
| Долгор Бямба А | 3-р хороо 5-39 Г-52826 | | 1945 оны 5-р сарын 17-н дээр Монголын Ардын Засгийн Газрын Зөвлөлийн Төрийн Зөвлөл 1945-10-25 Бүтээгдсэн | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 |
| Дампил Цэцэг | 5-р хороо 13-39 Г-52826 | | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 |
| Нямпил Цэцэг | 3-р хороо Г-3-15-1 | | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 |
| Самдан Ганзориг | 5-р хороо 13-39 Г-52826 | | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 |
| Дампил Алхаатар | 3-р хороо Г-3-15-1 | | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 | 1945 оны 5-р сарын 17-н 1945-10-25 |

Батлан хамгаалах яамны архиваас Дайнд оролцсон ахмад дайчдад үнэмлэх олгосон бүртгэлийг анх удаа дэглэв



Цэрэнхандын Дашийн Чөлөөлөх дайнд оролцсон үнэмлэх, баримт бичиг



тус музейн сан хөмрөгт өгсөн түүхтэй.

Монгол цэргийн музейн мэргэжлийн албаны дарга, эрдэм шинжилгээний ажилтан А.ГАНГАНЧИМЭГ

Улаанбаатар хот,
Баянзүрх дүүрэг, Офицеруудын ордон
Индекс 10018

И-мэйл хаяг:
Mil_newssouyombo@yahoo.com
Утас: 70001029

СОЁМБО СОНИН
“Соёмбо” сонин 96 дахь жилдээ
хэвлэгдэж байна.
Үндэслэгч нь: Н.ЖАДАМБА,
Л.НАЦАГДОРЖ

Эрхлэгч
Хурандаа
Батжаргалын
ОТГОНБАЯР

Эхийг “Соёмбо” сонин
релаксад бэлтгэж,
“Соёмбо принтинг” хэвлэх
үйлдвэрт хэвлүүлэв.

*Зар, рекламг хямд нийтэлнэ.
*Зар, рекламг үнэн зөв, эсэхийг нийтлүүлсэн байгууллага, хувь хүн хариуцна.
*Зохиогчийн үзэл бодол сонинг нийтлэхийн бодлогод нийцэхгүй байж болно.
*Тус сонинг мэдээллийг нэр заан ашиглаж болно.